

**ХАН-УУЛ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2017 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ КАЛЕНДАРЧИЛСАН
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЖИЛИЙН ЭЦСИЙН БИЕЛЭЛТ**

2017 оны 12 дугаар сарын 28-ны өдөр

№	2017 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Хариуцан хэрэгжүүлэх албан хаагч	Төсөв өртөг /сая төгрөг/	Сар				Биелэлт	Хувь
				I	II	III	IV		
НЭГ.ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ХЭЛТЭС									
1	Улсын Их Хурал, Засгийн газрын тогтоол, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж биелэлтийг хүргүүлж ажиллана.	ТЗУХ-ийн Иргэдийн өргөдөл, гомдол, санал, хүсэлт, тогтоол, шийдвэрийн биелэлт хариуцсан мэргэжилтэн Л.Отгонбаяр						2017 оны эхний хагас жилийн байдлаар биелэлтийг мэдээлэх 11 тогтоол шийдвэрийн холбогдох 13 заалтын хэрэгжилт 53.4 хувьтай хэрэгжсэн. 2017 оны жилийн эцсийн байдлаар Ерөнхийлөгчийн зарлиг, ҮАБЗ-ийн хуралдааны тэмдэглэл, Засгийн газрын тогтоол, НИТХ-ын тогтоол зэрэг 7 төрлийн 55 захирамжлалын баримт бичгийн хяналтад авсан 86 заалтын хэрэгжилт 94.2 хувьтай хэрэгжсэн байна. ЗГ-ын 89 дүгээр тогтоолоор "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам", Нийслэлийн Засаг даргын А/335 дугаар захирамжаар "Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийх, мэдээллийн сан бүрдүүлэх журам" тус тус батлагдаж, ЗГ-ын 2013 оны 322 дугаар тогтоол, нийслэлийн ЗД-ын 2013 оны А/1146 дугаар захирамж хүчингүй болсонтой холбогдуулан Засаг даргын 2017 оны Захирамжлалын баримт бичгийн хэрэгжилтийг эрчимжүүлж, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх тухай А/362 дугаар захирамжаар байгуулагдсан ажлын хэсгээс 2017 оны 11 сарын 16-ны өдөр дээрх шинээр батлагдан гарсан журмын дагуу Тамгын газрын болон Засаг даргын дэргэдэх хэлтэс, албадын захирамжлалын баримт бичгийн хэрэгжилт хариуцсан 18 мэргэжилтнүүдэд сургалт	94.2

								зохион байгуулж, арга зүйн зөвлөгөө, зааварчилгаа өгсөн. Тогтоол шийдвэрийн биелэлтийг жилийн эцсийн байдлаар гаргаж, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлгүүлэн 2017 оны 12 сарын 20-ны өдөр НЗДТГ-ын Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэст тайлагнасан.	
2	Нийслэлийн Засаг даргын захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, биелэлтийг хүргүүлж ажиллана.	ТЗУХ-ийн Иргэдийн өргөдөл, гомдол, санал, хүсэлт, тогтоол, шийдвэрийн биелэлт хариуцсан мэргэжилтэн Л.Отгонбаяр						<p>2017 оны 1 дүгээр улиралд Нийслэлийн Засаг даргын 33 захирамжийн хяналтад авсан 46 заалтын хэрэгжилтийг тооцож, Leader monitoring програмд байршуулсан. /Биелэлт 46,08 хувь /</p> <p>2017 оны 2 дугаар улиралд нийт 38 захирамжлалын баримт бичгийн хяналтад авсан 56 заалтын биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийгдэж биелэлт 60,1 хувьтай үнэлэгдсэн. Дүүргийн Засаг даргын зөвлөлийн гишүүдэд танилцуулсан илтгэх хуудсыг НЗДТГ-ын ХШҮ-ний хэлтэст хүргүүлсэн.</p> <p>2017 оны 3 дугаар удиралд Нийслэлийн Засаг даргын 32 захирамжийн хяналтад авсан 37 заалтын хэрэгжилтийг тооцож, Leader monitoring програмд байршуулсан. /Биелэлт 94,05 хувь /</p> <p>2017 оны 4-р улирлын байдлаар нийт 51 захирамжийн 77 заалтын хяналтад авсан 77 заалтын хэрэгжилтийг тооцов. /Биелэлт 98 хувь/ Биелэлт тооцсон захирамжлалын баримт бичгийн мэдээнд , хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлгүүлэн 2017 оны 12 дугаар сарын 20-ны өдөр НЗДТГ-ын Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэст тайлагнасан.</p>	98
3	Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, биелэлтийг хүргүүлж ажиллана	ТЗУХ-ийн Иргэдийн өргөдөл, гомдол, санал, хүсэлт, тогтоол, шийдвэрийн биелэлт хариуцсан мэргэжилтэн Л.Отгонбаяр						2017 оны жилийн эцсийн байдлаар ДИТХ болон Тэргүүлэгчдийн нийт 12 тогтоолын хяналтад авсан 12 заалтын хэрэгжилт 98.7 хувьтай хэрэгжсэн байна. Биелэлтийг ЗДТГ-ын даргын 2017 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 01/2202 тоот албан бичгээр хүргүүлсэн.	98.7

4	Нийслэлийн иргэдтэй холбогдох 1800-1200 тусгай дугаар, Засгийн газрын 11-11 төвийн утсаар ирүүлсэн иргэдийн эрэлт хүсэлтийг хүлээн авч, холбогдох байгууллага, хэлтэс, албадад хүргүүлж, шийдвэрлэлтийн явцад хяналт тавих.	ТЗУХ-ийн Иргэдийн өргөдөл, гомдол, санал, хүсэлт, тогтоол, шийдвэрийн биелэлт хариуцсан мэргэжилтэн Л.Отгонбаяр					Жилийн эцсийн байдлаар 1800-1200 тусгай дугаарын утсаар 46 өргөдөл хүлээн авснаас 45 өргөдлийг хугацаанд нь шийдвэрлэж, 1 өргөдөл шийдвэрлэх шатанд хяналтад байна. Засгийн газрын 11-11 төвөөс 176 өргөдөл хүлээн авснаас 174 өргөдлийг хугацаанд нь шийдвэрлэж, 2 өргөдөл шийдвэрлэх шатанд хяналтад байна.	100
5	Дүүргийн төр, захиргааны байгууллагын Удирдах ажилтны шуурхай зөвлөгөөнийг журмын дагуу зохион байгуулж, Нийслэл, дүүргийн шуурхайгаас өгөгдсөн үүрэг даалгаврын биелэлтийг хангуулж хугацаанд нь мэдээлж ажиллах	ТЗУХ-ийн Иргэдийн өргөдөл, гомдол, санал, хүсэлт, тогтоол, шийдвэрийн биелэлт хариуцсан мэргэжилтэн Л.Отгонбаяр					Нийслэлийн төр захиргааны байгууллагын удирдах ажилтны шуурхай зөвлөгөөн 21 удаа зохион байгуулагдаж, нийт 90 үүрэг даалгавар өгөгдсөн байна. /Биелэлт 90,57 хувь/ Дүүргийн төр, захиргааны байгууллагын удирдах ажилтны шуурхай зөвлөгөөнийг 11 удаа зохион байгуулж, 97 үүрэг даалгавар өгөгдсөн нь 90,23 хувьтай хэрэгжсэн байна. Шуурхай зөвлөгөөнөөс өгөгдсөн 97 үүрэг даалгавар болон биелэлтийг http://www.khanuul.mn/ сайтад тухай бүр байршуулсан. Нийслэлийн удирдах ажилтны шуурхай зөвлөгөөнөөс өгөгдсөн үүрэг даалгаврын биелэлтийг Ulaanbaatar.mn цахим хуудасны удирдлагын хэсэгт 21 удаа байршуулж ажилласан.	90
6	Засаг даргын Нийслэлийн төр,	ТЗУХ-ийн Иргэдийн өргөдөл,					Нийслэлийн төр, захиргааны байгууллагын удирдах ажилтны шуурхай зөвлөгөөнд мэдээлдэг дүүргийн 14 хоногийн Гэмт	100

	захиргааны байгууллагын удирдах ажилтны шуурхай зөвлөгөөнд 14 хоног тутам танилцуулах мэдээллийг холбогдох хэлтэс, албадаас авч боловсруулалт хийж бэлтгэх	гомдол, санал, хүсэлт, тогтоол, шийдвэрийн биелэлт хариуцсан мэргэжилтэн Л.Отгонбаяр						хэрэг, зам тээврийн осол, аваарын нөхцөл байдал, Онцгой комиссын мэдээлэл, Газрын харилцааны зөрчил, Хөрөнгө оруулалтын ажлын явц, үр дүнгийн талаарх мэдээллийг холбогдох хэлтэс, албадаас хүлээн авч нэгтгэн, дүн шинжилгээ хийж НЗДТГ-ын Хяналт, шинжилгээ-үнэлгээний хэлтэст 21 удаа хугацаанд нь хүргүүлж ажилласан.	
7	Засаг даргын иргэдтэй хийх уулзалтыг журмын дагуу зохион байгуулж, тэмдэглэл хөтлөн иргэдээс тавьсан санал хүсэлтийн шийдвэрлэлтэд хяналт тавьж ажиллах	ТЗУХ-ийн Иргэдийн өргөдөл, гомдол, санал, хүсэлт, тогтоол, шийдвэрийн биелэлт хариуцсан мэргэжилтэн Л.Отгонбаяр						<p>Дүүргийн Засаг даргын 2017 оны 02 дугаар сарын 16-ны өдрийн А/38 дугаар захирамжаар “Дүүргийн удирдах албан тушаалтнуудын иргэдтэй хийх уулзатад ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай журам” баталсан.</p> <p>Дүүргийн Засаг дарга долоо хоногийн Мягмар гарагт тогтмол, шаардлагатай тохиолдолд пүрэв гарагт батлагдсан хуваарийн дагуу иргэдийг хүлээн авч уулзан санал, хүсэлтийг сонсон шийдвэрлэж, хариу өгч байна.</p> <p>Засаг дарга 8 удаагийн хуваарьт уулзалтаар нийт 81 иргэнийг хүлээн авч, хүсэлтийг нь сонсож хариулт өгсөн.</p> <p>Уулзалтаар иргэдээс тавьж буй санал, хүсэлтийг газар дээр шийдвэрлэж, хариу өгөх зорилгоор чиг үүргийн хамааралтай хэлтэс албадын удирдлагуудыг оролцуулж, шийдвэрлэх боломжтой санал, хүсэлтийг шуурхай шийдвэрлэж байна.</p> <p>Уулзалтаар Засаг даргад хандаж хүсэлт гаргасан иргэдээс Ахмадын орон сууц болон Түрээсийн орон сууцанд хамрагдах, газрын асуудлаар, мөнгөн тусламж хүссэн асуудлаар ихэвчлэн хандаж байгаа бөгөөд гэр, орон сууц хүссэн 15 иргэдээс түрээсийн орон сууцанд хамрагдах хүсэлт гаргасан 13 иргэний хүсэлтийг “Төрийн орон сууцны корпорац” ТӨҮГ-т уламжилж, газрын харилцаатай холбоотой хүсэлт гаргасан 21, ТҮЦ-ийн асуудлаар хандсан 4 иргэний хүсэлтийг газрын</p>	100

								албанд шилжүүлэн судлуулж, шийдвэрлэж байна. Хөдөлмөр эрхлэлт, халамжийн үйлчилгээний асуудлаар хандсан 15 иргэний хүсэлтийг Хөдөлмөр халамжийн үйлчилгээний хэлтсээр судлуулж үйлчилгээнд хамруулж байна. Эмчилгээний төлбөр, оюутны сургалтын төлбөрт дэмжлэг хүсэх, буцалтгүй тусламж хүсч хандсан нийт 10 иргэний хүсэлтийг судалж 2 иргэнд 700 000 /долоон зуун мянган/ төгрөгийн дэмжлэг үзүүлсэн байна. Бусад санал хүсэлтийн хувьд зөвлөгөө өгөх, уулзалтын үед шууд хариу өгөх хэлбэрээр шийдвэрлэсэн байна.	
8	Иргэдээс төрийн байгууллага албан тушаалтанд хандан гаргасан өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн байдал үр дүнг эрчимжүүлэн , өргөдөл, гомдлын нэгдсэн програмын ашиглалтыг тогтмолжуулж, шийдвэрлэлтийг нийслэлийн түвшинд хүргэж ажиллана.	ТЗУХ-ийн Иргэдийн өргөдөл, гомдол, санал, хүсэлт, тогтоол, шийдвэрийн биелэлт хариуцсан мэргэжилтэн Л.Отгонбаяр					Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль, Нийслэлийн Засаг даргын 2016 оны А/1086 дугаар захирамжаар батлагдсан “Нийслэлийн нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтанд хандсан өргөдөл гомдлыг шийдвэрлэх журмыг мөрдөж, өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийг эрчимжүүлэх, шийдвэрлэлтийн дундаж хугацаар зорилтод түвшинд хүргэхээр зорин ажиллалаа. Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газарт 2017 оны 12 дугаар сарын 11-ний байдлаар иргэдээс 817 өргөдөл, гомдол, санал, хүсэлт ирүүлсэн байна. Үүнээс 800 өргөдөл, гомдлыг хуулийн хугацаанд, 10 өргөдлийг хугацаа хэтрүүлэн шийдвэрлэж, 7 өргөдөл, гомдол шийдвэрлэх шатанд, хяналтад байна. Шийдвэрлэлтийн дундаж хугацаа 11 хоног, 03 цаг, 23 минут байна. Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийг эрчимжүүлэх чиглэлээр: “Өргөдөл гомдлын нэгдсэн системийн ашиглалт түүнтэй холбогдох хууль, журмын хэрэгжилтийг хангуулахад зөвлөн туслах удирдамжийг ЗДТГ-ын даргаар батлуулан НЗДТГ-ын НҮНТөвтэй хамтран 09 дүгээр сарын 27, 28, 29-ний өдрүүдэд	90	

							<p>дүүргийн 16 хороодод өргөдөл, гомдлын нэгдсэн системд өргөдөл бүртгэж, уламжлах, шийдвэрлэх, хариу өгч буй байдалтай газар дээр нь танилцаж шаардлагатай зөвлөгөө, мэдээллээр ханган ажиллалаа.</p> <p>Хороодын Нэгдсэн системийн ашиглалтыг сайжруулах зорилгоор 2017 оны 10, 11 сард 14 хоногийн давтамжтайгаар дүүргийн 1, 2, 3, 4, 5, 6, 7, 8, 9, 10, 11, 12, 13, 14, 15, 16-р хороодод хуваарийн дагуу шалган туслах ажил хийгдсэн.</p> <p>2017 оны 11 дүгээр сарын 17-ны өдөр дүүргийн ИТХ-ын Хууль зүй, өргөдлийн хорооны гишүүдэд ЗДТГ, хороодын өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн тайланг бэлтгэж танилцуулсан. Мөн 11 дүгээр сарын 21-ний байдлаар албан хаагчдын ёс зүй сахилга хариуцлагатай холбогдолтой асуудлаар иргэдээс ирүүлсэн 8 гомдлын шийдвэрлэлтийн тайланг хүргүүлсэн.</p> <p>Шийдвэрлэлтийн хугацаа өссөн байгаа нөхцөл байдалд дүгнэлт хийж, өргөдөл, гомдлыг шуурхай шийдвэрлэхэд анхаарч шийдвэрлэлтийн үзүүлэлтийн тайланг бэлтгэж 7 хоног бүр ЗДТГ-ын шуурхай зөвлөгөөн, 14 хоног тутам хороодын шуурхай зөвлөгөөн дээр тус тус танилцуулж хэлтэс, албадын дарга болон хороодын Засаг дарга нарыг үүрэг чиглэлээр хангуулж ажиллалаа. Мөн жилийн хугацаанд давхардсан тоогоор 1400 гаруй иргэдэд хариуцсан ажлын чиг үүргийн хүрээнд мэдээлэл, арга зүйн зөвлөгөө өгч ажилласан Шийдвэрлэлт удаашралтай, шийдвэрлэлтийн явцад зөрчил үүссэн байгаа тохиолдолд шийдвэрлэлтийг эрчимжүүлж ажиллахыг тухайлсан мэргэжилтнүүдэд анхааруулж байна.</p> <p>Иргэдийн хандалтад дүн шинжилгээ хийж үзэхэд: Эмчилгээний төлбөр, оюутны сургалтын төлбөрт дэмжлэг хүсэх, буцалтгүй тусламж хүсэх, СӨХ, Түрээсийн орон сууцанд хамрагдахад дэмжлэг хүсэх, гэр хүсэх, худалдаа, үйлдвэрлэл үйлчилгээ явуулах гэрээний хугацаа сунгах гэсэн асуудлаар ихэвчлэн хандаж байна. 2017 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн байдлаар Засаг даргад буцалтгүй тусламж хүсч хандсан 1-16 дугаар хорооны 81 иргэнд дүүргийн Засаг</p>
--	--	--	--	--	--	--	---

								<p>даргын 2014 оны А/111 дүгээр захирамжаар батлагдсан “Иргэдээс мөнгөн тусламж хүссэн өргөдөл, гомдол, хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэх тухай журам”-ын дагуу 8 удаагийн /2017 оны А/37, А/44, А/78, А/124, А/183, А/249, А/279, А/324 дүгээр захирамж / захирамжаар нийт 22 610 000 / хорин хоёр сая зургаан зуун арван мянган/ төгрөгийн буцалтгүй тусламж олгосон байна.</p> <p>Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн тайланг улирал бүр тухайн сарын 25-ны өдрөөр тасалбар болгон НҮНТ-д тайлагнаж ажиллалаа. 2017 оны жилийн эцсийн тайланг ЗДТГ-ын даргын 12 дугаар сарын 27-ны өдрийн 01/2285 тоот албан бичгээр НЗДТГ-т хүргүүлсэн.</p>	
9	<p>Засаг даргын зөвлөлийн хурлыг журмын дагуу зохион байгуулж, хурлаас гарсан шийдвэрийн хэрэгжилтийг хангуулан мэдээлж, 14 хоног тутамд 1 удаа зохион байгуулж, хэрэгжилт, үр дүнг тайлагнаж, биелэлт ийг тооцох.</p>	<p>ТЗУХ-ийн Засаг даргын зөвлөлийн хурал шагнал хариуцсан мэргэжилтэн Ч.Мөнхгэрэл</p>					<p>2017 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн А/18 тоот тогтоолоор “Алдарт эх”-ийн 1,2 дугаар зэргийн одонгоор шагнагдах 389 эхчүүдийн материалыг дэмжүүлэн Нийслэлийн ИТХ-ын ажлын алба, нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлсэн. Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2016 оны 05 дугаар сарын 25-ны 122 дугаар зарлигаар дүүргийн хэмжээнд 18 эх “Алдар эх” 1 дүгээр зэргийн одонгоор, 378 эх “Алдар эх” 2 дугаар зэргийн одонгоор тус тус шагнагдлаа. “Ээж бол ертөнц” баярын арга хэмжээг 2017 оны 06 дугаар сарын 02-ны өдөр Соёлын төв өргөөнд зохион байгуулж, дүүргийн ИТХ-ын эмэгтэй төлөөлөгчидтэй хамтран 1200 ээжид баяр хүргэлээ. Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга Б.Цэрэн, Дүүргийн Засаг дарга Ж.Алдаржавхлан болон УИХ-ын гишүүд, Нийслэл, дүүргийн Төлөөлөгчид одон гардуулах ёслолын ажиллагаанд оролцож ээжүүдэд одонг нь гардуулан өгсөн.</p>	100	
10	<p>Дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллага,</p>	<p>ТЗУХ-ийн Засаг даргын зөвлөлийн хурал шагнал хариуцсан мэргэжилтэн Ч.Мөнхгэрэл</p>					<p>Төрийн дээд одон, медалиар шагнуулахаар нэр дэвшүүлсэн 139 иргэний материал тодорхойлогдсон. Үүнээс: 1 иргэнийг Монгол Улсын “Гавьяат жүжигчин”, 1 иргэнийг “Аж үйлдвэрийн гавьяат,” 1 иргэнийг, “Гавьяат холбоочин”, 4 иргэнийг Монгол Улсын “Гавьяат багш” цолоор, 1 иргэнийг “Соёлын гавьяат зүтгэлтэн”, 1 иргэнийг “Гавьяат нисгэгч”, 1</p>	100	

	иргэдээс Монгол Улсын Төрийн дээд одон медалиар шагнуулахаар нэр дэвшигдэж ирсэн иргэдийн материалын бүрдэлтийг хянан шалгаж холбогдох дээд шатны байгууллагад уламжлан хүргүүлэх							иргэнийг “ХАА-н гавьяат ажилтан”, 18 иргэнийг “Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одон”-оор, 4 иргэнийг “Цэргийн гавьяаны улаан тугийн одон”-оор, 46 иргэнийг “Алтан гадас одон”-оор, 60 иргэнийг “Хөдөлмөрийн хүндэт медаль”, 2 иргэнийг “Цэргийн хүндэт медаль”-аар тус тус шагнуулахаар тодорхойлолтыг дэмжиж батлуулсан. Тус иргэдийн мэдээллийг intranet.gov.mn програмд оруулж, нийслэлийн шагнал хариуцсан мэргэжилтэнд хүлээлгэн өгсөн. Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2017 оны 20, 48 дугаар зарлигаар Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одонгоор 13, Алтан гадас одонгоор 80, хөдөлмөрийн хүндэт медалиар 19 иргэнийг тус тус шагнуулсан.	
11	Засгийн газар, яамны шагналаар шагнуулахаар тодорхойлогдож ирсэн иргэдийн материалыг шагналын журмын дагуу бүрдэлтийг шалган авч холбогдох яам руу уламжлан хүргүүлэх	ТЗУХ-ийн Засаг даргын зөвлөлийн хурал шагнал хариуцсан мэргэжилтэн Ч.Мөнхгэрэл						Засгийн газар, яамны шагналаар шагнуулахаар албан бичиг ирүүлсэн байгууллага, аж ахуйн нэгжийн хүсэлтийг судлан үзээд: Зам, тээврийн яаманд 4, Хүнс, хөдөө аж ахуйн яаманд 3, Хууль зүйн яаманд 2, Боловсрол соёл шинжлэх ухааны яаманд 6 нийт 18 иргэний материалыг дэмжин уламжилж холбогдох яамдад хүргүүлсэн.	100
12	Нийслэл, дүүргийн Засаг даргын шагналаар шагнуулахаар тодорхойлогдон ирсэн иргэдийн материалын бүрдлийг шалган авч шагналын	ТЗУХ-ийн Засаг даргын зөвлөлийн хурал шагнал хариуцсан мэргэжилтэн Ч.Мөнхгэрэл						Нийслэлийн Засаг даргын шагналаар: Нийслэлийн Засаг даргын шагналаар шагнагдах 5 иргэний материалыг хүргүүлж, Нийслэлийн тэргүүний ажилтанаар 3 албан хаагч шагнагдсан. Дүүргийн Засаг даргын шагналаар: Татвар төлөгчдийн өдөрлөгөөр 2016 онд шилдэг татвар төлөгчөөр шалгарсан 20 аж ахуйн нэгж, байгууллагыг Засаг даргын “Өргөмжлөл”-өөр шагналаа. Мөн “Хүндэт тэмдэг”ээр 10, “Жуух бичиг”-ээр 111, “Өргөмжлөл”-өөр 206, “Хан-Уул	100

	ажлын хэсгийн хурлаар хэлэлцэн шийдвэрлэх, шагнал гардуулах үйл ажиллагааг зохион байгуулах						авьяастан медаль"-аар 13, нийт 327 иргэнийг Засаг даргын шагналаар тус тус шагнасан байна.	
13	Алдарт эхийн I, II зэргийн одонгоор шагнуулах хүсэлт гаргасан эхчүүдийн материалыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу хороодоос хүлээн авч нэгтгэн дээд шатны байгууллагад уламжлан хүргүүлэх, одон гардуулах үйл ажиллагааг зохион байгуулах	ТЗУХ-ийн Засаг даргын зөвлөлийн хурал шагнал хариуцсан мэргэжилтэн Ч.Мөнхгэрэл					2017 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн А/18 тоот тогтоолоор "Алдарт эх"-ийн 1,2 дугаар зэргийн одонгоор шагнагдах 389 эхчүүдийн материалыг дэмжүүлэн Нийслэлийн ИТХ-ын ажлын алба,НЗДТГ-т хүргүүлсэн. Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2016 оны 05 дугаар сарын 25-ны 122 дугаар зарлигаар дүүргийн хэмжээнд 18 эх "Алдар эх" 1 дүгээр зэргийн одонгоор, 378 эх "Алдар эх" 2 дугаар зэргийн одонгоор тус тус шагнагдлаа. "Ээж бол ертөнц" о дон гардуулах баярын арга хэмжээг 2017 оны 06 дугаар сарын 02-ны өдөр Соёлын төв өргөөнд дүүргийн ИТХ-ын эмэгтэй төлөөлөгчидтэй хамтран зохион байгуулсан. Арга хэмжээнд 1200 ээж оролцож, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга Б.Цэрэн, Дүүргийн Засаг дарга Ж.Алдаржавхлан болон УИХ-ын гишүүд, Нийслэл, дүүргийн төлөөлөгчид одон гардуулах ёслолын ажиллагаанд оролцон ээжүүдэд одонг нь гардуулан өгч хүндэтгэл үзүүллээ.	100
14	Тамгын газрын хэлтэс, албадын үйл ажиллагааны тайланг 14 хоног, сар, улирал, хагас, бүтэн жилээр хүлээн авч нэгтгэх холбогдох дээд шатны байгууллагад тайлагнах,	ТЗУХ-ийн Захиргааны зохион байгуулалт хариуцсан мэргэжилтэн Ч.Ариунжаргал					Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газрын хэлтэс албадын үйл ажиллагааны тайланг 14 хоног, сар, хагас жил, жилийн эцсээр хэлтэс, тасгуудаас хүлээн авч Засгийн газрын 89 дүгээр тогтоол болон нийслэлийн Засаг даргын 2017 оны А/335 дугаар захирамжийн хавсралтад заасан журмын дагуу нэгтгэн боловсруулж, холбогдох албан тушаалтад танилцуулан баталгаажуулж, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт шинжилгээ-үнэлгээний хэлтэст тайлант хугацаанд нь цахимаар болон албан бичгээр хүргүүлэн ажилласан.	100

	гүйцэтгэлд үнэлэлт, дүгнэлт өгч бодлогын зөвлөмжөөр хангаж, биелэлтийг тооцох								
15	Тамгын газрын даргын үр дүнгийн гэрээ, гэрээний биелэлтийг гаргаж дүгнүүлэх	ТЗУХ-ийн Захиргааны зохион байгуулалт хариуцсан мэргэжилтэн Ч.Ариунжаргал						Төсвийн Шууд захирагч Төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулах 2017 оны Үр дүнгийн гэрээнд тусгах үзүүлэлтүүдийг Тамгын газрын хэлтэс, тасгуудтай тохирч, Тамгын газрын даргын Үр дүнгийн гэрээний 1 дүгээр хавсралтын үндсэн 3 заалтын хүрээнд нийт 169 ажил үйлчилгээ, 2 дугаар хавсралт болох календарьчилсан төлөвлөгөөнд 186 ажлыг хэрэгжүүлж ажиллахаар тус тус тусгуулан гэрээний төслийг боловсруулан Үр дүнгийн гэрээг баталгаажуулж, хагас жилийн байдлаар хувь буюу "А" , жилийн эцсийн байдлаар хувь буюу "А" үнэлэгдсэн.	95
16	Тамгын газрын албан хаагчдын аппаратын зөвлөгөөнийг зохион байгуулах, өмнөх зөвлөгөөн дээр гарсан санал, шүүмжлэлийн биелэлтийг гаргаж мэдээлэх, тэмдэглэл хөтлөх, санал, хүсэлтийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах	ТЗУХ-ийн Захиргааны зохион байгуулалт хариуцсан мэргэжилтэн Ч.Ариунжаргал						Тамгын газрын албан хаагчдын аппаратын зөвлөгөөнийг 2017 оны 12 дугаар сарын 21-ний өдөр зохион байгуулсан бөгөөд хурлаар хэлтэс, тасгуудын үйл ажиллагааны жилийн эцсийн тайланг сонсож, Засаг даргын Тамгын газрын дарга 2017 оны ажлын алдаа, оноо, 2018 онд хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаа томоохон ажлуудын талаар санал бодлоо илэрхийллээ. Зөвлөгөөнд 8 хэлтэс, тасгийн нийт 63 албан хаагч оролцсон.	100
17	Засаг даргын Тамгын газрын хэлтэс, албадаас Тамгын газрын	ТЗУХ-ийн Захиргааны зохион байгуулалт хариуцсан						Засаг даргын Тамгын газрын хэлтэс, албадаас Тамгын газрын 2017 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгах ажлын саналыг авч, нэгтгэн боловсруулсан бөгөөд төлөвлөгөөнд нийт 189 ажил тусгагдсанаас хагас жилийн	95.1

	төлөвлөгөөнд тусгах ажлын саналыг авч, нэгтгэн батлуулж, биелэлтийг хагас, бүтэн жилээр гаргах	мэргэжилтэн Ч.Ариунжаргал						байдлаар 62.6, жилийн эцсийн байдлаар 95.1 хувь биелэлттэй хэрэгжсэн байна.	
18	Засаг даргын Тамгын газрын шуурхай зөвлөгөөнийг зохион байгуулах, шуурхайгаас өгөгдсөн үүрэг даалгаварын биелэлтэд хяналт тавих, Тамгын газрын дотоод ажлыг уялдуулан зохицуулах, зохион байгуулах, ажлын үр дүнг тооцох, мэдээлэх	ТЗУХ-ийн Захиргааны зохион байгуулалт хариуцсан мэргэжилтэн Ч.Ариунжаргал						Засаг даргын Тамгын газрын шуурхай зөвлөгөөнийг нийт 30 удаа зохион байгуулсан бөгөөд шуурхай зөвлөгөөнөөс 238 үүрэг даалгавар өгөгдөж, 2017 оны жилийн эцсийн байдлаар 94%-тай хэрэгжсэн байна.	94
19	Засаг даргын дэргэдэх хэлтэс, албадын тайлан, төлөвлөгөөг 14 хоног, сар, хагас, бүтэн жилээр хүлээн авах, гүйцэтгэлд хяналт тавьж, бодлогын зөвлөмжөөр хангах	ТГХШХ						Засаг даргын дэргэдэх хэлтэс, албадын тайлан мэдээг 14 хоног тутам хүлээн авч бодлогын зөвлөмжөөр ханган хамтран ажиллаж байна. Төлөвлөлт, гүйцэтгэлийн хяналт шинжилгээний хэлтсээс дараах ажлуудыг хэрэгжүүлж эхлээд байна. Засаг даргын Тамгын газар болон дэргэдэх хэлтэс, албадын үйл ажиллагаанд урьдчилсан болон явцын Хяналт, шинжилгээ, үнэлгээ хийх тухай А/57 дугаар тушаал, Засаг даргын дэргэдэх хэлтэс, албадын үйл ажиллагааны үр дүнд хийх ХШҮ-ний төлөвлөгөө, удирдамжийг дүүргийн Засаг даргын 2017 оны А/123 дугаар захирамжаар батлуулж, Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд танилцуулсан. Мөн Засаг даргын	100

								дэргэдэх хэлтэс, албадын 2017 оны эхний хагас жилийн тайлан нэгтгэх ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг байгуулах тухай захирамжийн төсөл, албан бичиг, өргөдөл гомдлын шийдвэрлэлтэд ХШҮ хийх ажлын төлөвлөгөөний төслийг тус тус боловсруулан Засаг даргын Тамгын газрын даргад танилцуулав. Засгийн газрын 2017 оны А/89 дүгээр тогтоолын дагуу нийслэлийн Засаг даргын 2013 оны А/1146 дугаар захирамжаар батлагдсан журмыг 2017 оны А/335 дугаар захирамжаар шинэчлэн баталсан тул дүүргийн ХШҮ-ний төлөвлөгөөг мөн шинэчлэн боловсруулж, батлуулахаар ажиллаж байна.	
20	Тамгын газрын албан хаагчдын үр дүнгийн гэрээ байгуулах ажлыг зохион байгуулж, дүгнүүлэх, архивын нэгж үүсгэн архивт хүлээлгэн өгөх	ТЗУХ-ийн Захиргааны зохион байгуулалт хариуцсан мэргэжилтэн Ч.Ариунжаргал						Засаг даргын Тамгын газрын 49 албан хаагч Нэгжийн менежерүүдтэй, нэгжийн менежерүүд Төсвийн шууд захирагчтай 2017 оны 01 дүгээр сарын 16-ны өдөр Үр дүнгийн гэрээ байгуулах ажлыг хариуцан зохион байгуулсан. 2016 онд гэрээ байгуулж ажилласан албан хаагчдын үр дүнгийн гэрээг хүлээн авч архивын нэгж үүсгэн архивт хүлээлгэн өгсөн. 2017 оны үр дүнгийн гэрээ, илтгэх хуудсыг хуулийн хугацаанд нь архивт хүлээлгэн өгөхөөр цэгцэлж байна.	100
21	“Явуулын нэг цэгийн үйлчилгээ”-ээр төрийн үйлчилгээг 16 хороодын иргэдэд хүргэх ажлыг зохион байгуулах	ТЗУХ-ийн Захиргааны зохион байгуулалт хариуцсан мэргэжилтэн Ч.Ариунжаргал	8009					Хан-Уул дүүргийн Засаг даргын 2017-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан “Хорооны хөгжил –Төрийн үйлчилгээ” зорилтын хүрээнд тус дүүргийн иргэдэд төрийн үйлчилгээг нэг дороос ойр, хүртээмжтэй, хөнгөн шуурхай хүргэх зорилгоор дүүргийн Засаг даргын 2017 оны 11 дүгээр сарын 02-ны өдрийн А/360 дугаар захирамжаар “Явуулын нэг цэгийн үйлчилгээ”-г 2017 оны 11 дүгээр сарын 11-ний өдөр алслагдсан 12,13,14 дүгээр хороонд зохион байгууллаа. Нээлтийн арга хэмжээнд дүүргийн Засаг дарга Ж.Алдаржавхлан, Засаг даргын Тамгын газрын дарга Б.Энхболд болон хэлтэс, алба, хороодын дарга, иргэдийн төлөөлөл хүрэлцэн ирж оролцсон. Дээрх үйл ажиллагаанд дүүргийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтэс, Төлөвлөлт, гүйцэтгэлийн хяналт, шинжилгээний хэлтэс, Тохижилт,	100

							<p>нийтийн аж ахуйн хэлтэс, Цэргийн штаб, Хууль зүйн тасаг, Засаг даргын дэргэдэх Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэс, Эрүүл мэнд, нийгмийн даатгалын хэлтэс, Эрүүл мэндийн төв, Татварын хэлтэс, Албан бус насан туршийн боловсролын төв, Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих төв, Газрын алба, зэрэг 12 хэлтэс, алба, хороод хамтран оролцож, төр захиргааны байгууллагын 64 албан хаагчид 2229 иргэнд төрийн үйлчилгээг хүргэн ажиллалаа.</p> <p>Явуулын нэг цэгийн үйлчилгээг TV5 телевиз, ETV телевизийн мэдээллийн хөтөлбөрөөр тус тус 1 удаагийн давтамжтайгаар, MNB телевиз, Eagle телевизийн урсдаг зараар, мөн www.news.mn, Zaluu.com сайтуудад үйл ажиллагааны талаар мэдээ, мэдээлэл өгч ажиллалаа.</p>	
22	Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газар, хороодын Засаг дарга, хэсгийн ахлагч нарын сургалт, семинарыг зохион байгуулах	ТЗУХ-ийн Захиргааны зохион байгуулалт хариуцсан мэргэжилтэн Ч.Ариунжаргал	3486				<p>Тус дүүргийн хороодын хэсгийн ахлагч нарын ур чадварыг нэмэгдүүлэх зорилгоор 2017 оны 04 дүгээр сарын 26-ны өдрөөс 05 дугаар сарын 11-ний өдрүүдэд Швейцарын хөгжлийн агентлагийн санхүүжилттэйгээр Нийслэлийн Засаг даргын Тамгын газар Азийн сан хамтран хэрэгжүүлж буй Хотын засаглалыг сайжруулах төслийн хүрээнд 1, 6, 7, 8,11, 15,16 дугаар хорооны иргэн танхимд 3 хоног 1-16 дугаар хорооны нийт 172 хэсгийн ахлагчийг оролцуулан бүсчилсэн сургалтыг зохион байгууллаа. Тус сургалтаар хувь хүний ур чадвар, ажлын байранд тавигдах шаардлага, харилцааны ур чадвар, мэдээлэл цуглуулах, үнэлэх чадвар, ажлын байранд шаардагдах үндсэн чадварууд, хууль зүйн үндсэн мэдлэг ур чадвар, иргэдийн оролцоо ба хяналт сэдвүүдээр сургагч багш нар сургалтыг зохион байгууллаа.</p>	100
23	Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2015 оны “Авилгын эсрэг	Хүний нөөц, ёс зүй, хөрөнгө орлогын мэдүүлэг хариуцсан мэргэжилтэн					<p>Монгол Улсын Улсын Их Хурлын 51 дүгээр тогтоолоор баталсан “Авлигын эсрэг үндэсний хөтөлбөр”, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 23/01 дугаар тогтоолоор баталсан “Авлигын эсрэг нийслэлийн хөтөлбөр”-ийн 2017 оны төлөвлөгөөнд тусгагдсан хийж хэрэгжүүлэх ажлуудын хүрээнд</p>	100

	нийслэлийн хөтөлбөр, стратеги төлөвлөгөө батлах тухай” 23/01 дугаар тогтоолын хэрэгжилтийг зохион байгуулж ажиллана	Н.Сарангуа					<p>Дүүргийн Засаг даргын Тамгын газрын хэлтэс, тасгуудаас авилгын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгах саналыг авч нэгтгэн үүний дагуу 2017 оны Авилгын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан батлуулсан.</p> <p>Хөтөлбөрийн хүрээнд:</p> <p>1.Нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг хянасан дүгнэлтийг дүүргийн цахим хуудасны ил тод байдал буланд жагсаалт хэлбэрээр байршуулсан.</p> <p>2. Төрийн захиргааны төв байгууллагын хүний нөөцийн жагсаалтыг удирдлага болон хэлтэс, тасагт хувааж, албан хаагчдын мэдээллийг дүүргийн албан ёсны цахим хуудаст нээлттэй байршуулсан. Төрийн албанаас чөлөөлөгдсөн болон түр чөлөөлөгдсөн, албан хаагчдын тоог www.khanuul.mn сайтад байршуулсан.</p> <p>3. Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газрын Ажлын байр /албан тушаал/-ны тодорхойлолтыг шинэчлэн боловсруулах ажлын хэсэг байгуулагдан 2017 оны 02 дугаар сард ажлын байр /албан тушаал/-ны тодорхойлолтыг шинэчлэн баталж албан тушаалтанд тавигдах мэдлэг боловсрол, туршлага, ур чадвар зэрэг ерөнхий шалгуурыг шинэчилсэн.</p>	
24	Төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн тухай гомдол мэдээллийг Төрийн албаны зөвлөлийн 2010 оны 129 дүгээр тогтоолоор	Хүний нөөц, ёс зүй, хөрөнгө орлогын мэдүүлэг хариуцсан мэргэжилтэн Н.Сарангуа					<p>ЗДТГ-ын даргын 2017 оны А/21 дүгээр тушаалаар Ёс зүйн хорооны бүрэлдэхүүнийг шинэчлэн батлуулсан. ЗДТГ-ын даргын 2017 оны А/60 дугаар тушаалаар “Захиргааны ажилтны ажлын байранд дагаж мөрдөх харилцаа, хандлагын нийтлэг журам”-ыг боловсруулан баталж, ЗДТГ-ын болон хороодын албан хаагчдад таниулан сурталчилсан. Төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн тухай гомдол мэдээллийг хүлээн авч “Төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн дүрмийн хэрэгжилтийг зохион</p>	100

	батлагдсан “Төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн дүрмийн хэрэгжилтийг зохион байгуулах, ёс зүйн зөрчлийг хянан шийдвэрлэх журмын дагуу шийдвэрлэж, холбогдох хариуцлага хүлээнэ.							байгуулах, ёс зүйн зөрчлийг хянан шийдвэрлэх журам”-ын дагуу албан хаагчдад арга хэмжээ авч, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. ЗДТГ-ын Ёс зүйн хорооны үйл ажиллагааг цаг тухайд нь зохион байгуулж ЗДТГ-ын даргын 2017 оны А/21 дүгээр тушаалаар Ёс зүйн хорооны бүрэлдэхүүнийг шинэчлэн баталж дүүргийн ЗДТГ-ын даргын 2017 оны А/60 дугаар тушаалаар “Захиргааны ажилтны ажлын байранд дагаж мөрдөх харилцаа, хандлагын нийтлэг журам”-ыг батлан улмаар ЗДТГ, 16 хороодын албан хаагчдад таниулан сурталчлах ажлыг зохион байгууллаа.Төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн тухай гомдол мэдээллийг хүлээн авч “Төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн дүрмийн хэрэгжилтийг зохион байгуулах, ёс зүйн зөрчлийг хянан шийдвэрлэх журам”-ын дагуу албан хаагчдад арга хэмжээ авч хэрэгжилтийг ханган ажиллаж байна. 2017 оны жилийн эцсийн байдлаар албан тушаалтанд холбогдох ёс зүйтэй холбоотой нийт 8 өргөдөл, гомдол, мэдээллийг хүлээн авч тухай бүр ёс зүйн хороо хуралдан ТАТХ-ийн 26.1.1, 26.1.2 дахь заалтын дагуу арга хэмжээг авсан. Мөн шаардлагатай тохиолдолд Ажлын хэсэг байгуулан хянан шалгах үйл ажиллагаа явуулж байна.	
25	“Авилгын эсрэг нийслэлийн хөтөлбөр хэрэгжүүлж, авлигаас ангид төрийн албыг бэхжүүлсэн тунгалаг хот болгоно.	Хүний нөөц, ёс зүй, хөрөнгө орлогын мэдүүлэг хариуцсан мэргэжилтэн Н.Сарангуа						Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2015 оны “Авилгын эсрэг нийслэлийн хөтөлбөр, стратеги төлөвлөгөө батлах тухай ” 23/01 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангуулах хүрээнд Хан-Уул дүүргийн Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг дүүргийн Засаг даргын 2017 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн А/31 дүгээр захирамжаар батлуулан хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна. Төлөвлөсөн ажлын хүрээнд Авилгатай тэмцэх газартай хамтран ХУД-ийн ЗДТГ-ын ажилтан, албан хаагчдад 2017 оны 4 дүгээр сард урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр 7 хоногийн турш сургалт, зөвлөгөө, мэдээлэл хүргэн ажилласан. Дээрх төлөвлөгөөнд тусгасан хуваарьт болон хуваарьт бус ажлуудыг шат дараатай хийж гүйцэтгэж	100

							байна.	
26	“Төрийн албан хаагчдыг сургах, мэргэшүүлэх, хөгжүүлэх, нийгмийн баталгааг нь хангах хөтөлбөр” боловсруулж хэрэгжүүлнэ.	Хүний нөөц, ёс зүй, хөрөнгө орлогын мэдүүлэг хариуцсан мэргэжилтэн Н.Сарангуа					“Төрийн албан хаагчдыг сургах, мэргэшүүлэх, хөгжүүлэх, нийгмийн баталгааг нь хангах хөтөлбөр” боловсруулах ажлын хэсгийг Засаг даргын Тамгын газрын даргаар батлуулж, хөтөлбөрт тусгах саналыг Засаг даргын Тамгын газрын хэлтэс, тасаг, хороодоос хүлээн авахаар албан бичиг хүргүүлэн, саналыг авч, Засаг даргын Тамгын газрын даргын 2017 оны Б/563 дугаар тушаалаар “Төрийн албан хаагчдын нийгмийн баталгааг хангах хөтөлбөр”-ийг батлуулсан. Уг хөтөлбөрийн хүрээнд 2018 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг ЗДТГ-ын хэлтэс, тасгуудаас саналыг авч нэгтгэж байна.	100
27	Хүний нөөцийн удирдлагар бодлогын зөвлөгөө өгөх, Хүний нөөцийн холбогдолтой бичиг баримтын бүрдлийг хангах, шийдвэрийн төсөл боловсруулах, хэрэгжүүлэх	Хүний нөөц, ёс зүй, хөрөнгө орлогын мэдүүлэг хариуцсан мэргэжилтэн Н.Сарангуа					Хүний нөөцийн удирдлагаар бодлогын зөвлөгөө өгч, бичиг баримтын бүрдлийг 100 хувь хангаж, шийдвэрийн төсөл боловсруулан хэрэгжүүлж байна. 2017 оны жилийн эцсийн байдлаар хүний нөөцийн холбогдолтой 81 захирамж, 602 тушаал шийдвэр гарсан. Хүний нөөцийн холбоотой 108 албан бичиг ирснээс 108 албан бичгийг хугацаанд нь шийдвэрлэж, хариу өгсөн. Засаг даргын Тамгын газарт ирүүлсэн нийт 9 өргөдөл, гомдлыг Smart city програмаар хүлээн авч, 6 өргөдлийг шийдвэрлэж, холбогдох эзэнд нь хариу өгч ажиллалаа.	100
28	Төрийн албан хаагчийн бүртгэл, хувийн хэрэг хөтлөх.	Хүний нөөц, ёс зүй, хөрөнгө орлогын мэдүүлэг хариуцсан мэргэжилтэн Н.Сарангуа					ЗДТГ-ын Төрийн албан хаагчдын бүртгэл, хувийн хэргийг зохих журмын дагуу хөтлөн ажиллаж байна. Мөн ЗДТГ-ын албан хаагчдын бүртгэл мэдээллийг цахимжуулах, хүний нөөцийн цогц програмыг дотоод үйл ажиллагаандаа нэвтрүүлэхээр мэргэжлийн байгууллагатай хамтран ажиллахаар судлан 2018 оны эхний улиралд нэвтрүүлэн хэрэгжилтийг тогтворжуулахаар төлөвлөж байна.	100
29	Засаг даргын Тамгын газрын хэлтэс, албадын албан хаагчдын	Хүний нөөц, ёс зүй, хөрөнгө орлогын мэдүүлэг хариуцсан					Засаг даргын Тамгын газрын хэлтэс, тасгийн албан хаагчдын сургалтын хэрэгцээ шаардлагыг судлан, хэлтэс, тасаг, 16 хороодын албан хаагчдаас санал авч сургалтын төлөвлөгөөг боловсруулан 2017 оны Б/563 дугаар тушаалаар батлуулав.	100

	сургалтын хэрэгцээ шаардлагыг судлан санал, харьяа дээд байгууллагаас өгсөн зөвлөмжүүдийг үндэслэн Засаг даргын Тамгын газрын албан хаагчдын сургалтын төлөвлөгөөг боловсруулж хэрэгжүүлэх	мэргэжилтэн Н.Сарангуа						Мөн 2017 онд хэрэгжүүлэх сургалтын төлөвлөгөөг ЗДТГ-ын хэлтэс, тасгуудаас авч шат дараалсан арга хэмжээг авч, ЗДТГ-ын хэлтэс, тасгууд тухайн жилийн хуваарьт сарыг сонгон авч өөрсдийн гүйцэтгэн хэрэгжүүлэх сургалтын төлөвлөгөөг боловсруулан төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус сургалтын хүрээнд Засаг даргын Тамгын газар, 16 хороодын нийт 145 албан хаагчдад “Архив, албан хэрэг хөтлөлтийн edoc програмын сургалт”-ыг, “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх” тухай хуулийн шинэчилсэн найруулга, хамтарсан багийн тухай ойлголт зохион байгуулах сургалт, “Ажлын байрны стандартад нийцсэн хувцаслалт, биеэ зөв авч явах” сургалт, “Нийслэлийн ахуйн үйлчилгээний салбарын судалгааны санал асуулга, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх, аргачлалаар хангах сургалт семинар”, “Цаг ашиглалт, цаг төлөвлөх, зохион байгуулах ур чадвар”-ын сургалт, “Өргөдөл гомдлын Smartcity програмын” сургалт, Ёс зүйн сургалт зэрэг давтагдсан тоогоор нийт 30 гаруй сургалтыг зохион байгууллаа. Мөн Засаг даргын Тамгын газрын даргын санаачилгаар хэлтэс, тасгууд сарын аян зохион байгуулж, аяны хүрээнд чадавхжуулах чиглэлийн 1-2 удаагийн сургалтуудыг тогтмол зохион байгуулсан.	
30	Авлигын эсрэг хуулийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд Засаг даргын Тамгын газрын болон Засаг даргын дэргэдэх хэлтэс, албадаас авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгах саналыг нэгтгэн төлөвлөгөө	Хүний нөөц, ёс зүй, хөрөнгө орлогын мэдүүлэг хариуцсан мэргэжилтэн Н.Сарангуа					Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2015 оны “Авилгын эсрэг нийслэлийн хөтөлбөр, стратеги төлөвлөгөө батлах тухай ” 23/01 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангуулах хүрээнд Хан-Уул дүүргийн Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг дүүргийн Засаг даргын 2017 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн А/31 дүгээр захирамжаар батлуулан хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна. Төлөвлөсөн ажлын хүрээнд Авилгатай тэмцэх газартай хамтран ХУД-ийн ЗДТГ-ын ажилтан, албан хаагчдад 2017 оны 4 дүгээр сард урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр 7 хоногийн турш сургалт, зөвлөгөө, мэдээлэл хүргэн ажилласан. Дээрх төлөвлөгөөнд тусгасан хуваарьт болон хуваарьт бус ажлуудыг шат дараатай хийж гүйцэтгэж байна.	100	

	боловсруулж батлуулан хэрэгжүүлэх								
31	Төрийн албаны тухай хууль болон холбогдох стандартын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд төрийн захиргааны албан хаагчдын зэрэг дэв, төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл, болон бусад асуудлыг хуулийн дагуу тухай бүр шийдвэрлэх, хүний нөөцийн программ хангамжийг шаардлагатай мэдээллээр баяжуулж, холбогдох байгууллагад хуулийн хугацаанд тайлагнах	Хүний нөөц, ёс зүй, хөрөнгө орлогын мэдүүлэг хариуцсан мэргэжилтэн Н.Сарангуа						<p>1. Төрийн албаны тухай хууль болон холбогдох стандартын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд 11 төрийн захиргааны албан хаагчдын зэрэг дэв, түүний нэмэгдлийг 2017 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн олгуулан бусад асуудлыг хуулийн дагуу тухай бүр шийдвэрлэн хуулийн хугацаанд тайлагнан ажиллаж байна.</p> <p>2. Төрийн захиргааны төв байгууллагын хүний нөөцийн жагсаалтыг удирдлага болон хэлтэс, тасагт хувааж, албан хаагчдын мэдээллийг дүүргийн албан ёсны цахим хуудаст нээлттэй байршуулсан. Төрийн албанаас чөлөөлөгдсөн болон түр чөлөөлөгдсөн, албан хаагчдын тоог www.khanuul.mn сайтад байршуулсан.</p> <p>3.Төрийн албан хаагчдын бүртгэлийн нэгдсэн систем шинэчлэгдсэнтэй холбогдуулан ТАЗ-өөс сургалтад хамрагдан хуулийн хугацаанд албан хаагчдын мэдээллийг баяжуулан тайлагнахаар бэлтгэж байна.</p>	100
32	Засаг даргын Тамгын газрын нийт албан хаагчдын хувийн хэрэг болон холбогдох бичиг	Хүний нөөц, ёс зүй, хөрөнгө орлогын мэдүүлэг хариуцсан мэргэжилтэн Н.Сарангуа						Тус төлөвлөгөөт ажлыг хэрэгжүүлэхээр судалж үзээд 2017 онд Засаг даргын Тамгын газрын нийт албан хаагчдын дэлгэрэнгүй мэдээлэл, шагнал, сахилга хариуцлагын тухай мэдээллийг нарийн гарган тайлбарласан дотооддоо ашиглах хүний нөөцийн шинэ програмыг нэвтрүүлэн ажиллах хэрэгцээ шаардлага байгааг үндэслэн “шагналын карт” бус шинэ	90

	баримтыг шинэчлэн “шагналын карт” шинээр хавсарган баяжуулах.						програмаар тухайн албан хаагчийн нарийвчилсан мэдээллийг бүртгэн баяжуулалт хийхээр төлөвлөн, 2017 оны 4 дүгээр улиралд мэргэжлийн компанитай гэрээ байгуулан 2018 оны 1 дүгээр улиралд ашиглалтад оруулахаар төлөвлөн ажиллаж байна.	
33	Дүүргийг Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн даргатай үр дүнгийн гэрээ байгуулж, үд дүнг тооцож хагас бүтэн жилээр тайлагнана.	НАГ; Дүүргийн Засаг даргын Тамгын газар					Нэгжийн менежер буюу Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн даргатай 2017 оны 03 дугаар сарын 02-ны өдөр Хөдөлмөрийн гэрээ байгуулан бүтэн жилээр биелэлт гарган 2017 оны 12 дугаар сарын 08-ны өдөр дүгнүүлж ажилласан.	100
34	Архивын тасгийн ажилтнуудын ажлын байрны тодорхойлолтыг шинэчлэх, албан хэрэг хөтлөлт, түүний зохицуулалтыг хариуцсан ажилтан, Бичээчийн орон тоог тогтоосон журмын дагуу нэмж ажиллуулах	Архивын тасгийн дарга, Архивын арга зүйч					Нийслэлийн Засаг даргын 2016 оны 11 дүгээр сарын 23-ны А/832 захирамжаар “Дүүргийн Засаг даргын Тамгын газрын бүтэц, ажлын байрыг” баталсан. Дээрх захирамжийг үндэслэн дүүргийн Засаг даргын 2016 оны 12 дугаар сарын 22-ны өдөр А/486 дугаар захирамжаар “Дүүргийн Засаг даргын Тамгын газрын бүтэц, ажлын байрны жагсаалт батлагдан Архивын тасаг байгуулагдсан. Архивын тасаг нь Арга зүйч /Тасгийн дарга/, сургалт, арга зүй хариуцсан ажилтан, архивч, албан хэрэг хөтлөлт, түүний зохицуулалт хариуцсан ажилтан, бичээчийн оронтойгоор байгуулагдаж Нийслэлийн архивын газраас хүргүүлсэн ажлын байрны чиг үүргийн хүрээнд ажлын байрны тодорхойлолтоо шинэчилж батлуулан ажиллаж байна.	100
35	Цэцэрлэг сургуулийн нөхөн бүрдүүлэлттэй холбоотой мэдлэг,	Архивын арга зүйч					2017 оны 04 дүгээр сарын 14-ны өдөр Хан-Уул дүүргийн 27 дугаар цэцэрлэгийн 1989-2015 оны нийт 650 баримтанд 2015 оны А/177 захирамжаар батлагдсан “Архивын сан хөмрөгт нөхөн бүрдүүлэлт хийх ажлын нийтлэг журам”-ыг үйл	90

	дадлага олгох ажлын чиглэлээр “Үзүүлэх сургалт” зохион байгуулах						ажиллагаандаа мөрдөж баримтуудыг нэг бүрчлэн хянан шалгаж, Байнга, түр, 70 жил хадгалах бүртгэлд ангилан төрөлжүүлэх талаар 73, 28, 4-р яслын цэцэрлэгүүдийн архив бичиг хэрэг хариуцсан ажилтнуудад үзүүлэх сургалт зохион байгуулж 6 албан хаагч хамрагдсан.	
36	Дүүргийн архивт 2017 онд нөхөн бүрдүүлэлт хийх цэцэрлэг, сургууль болон дэргэдэх байгууллагуудын архив хариуцсан ажилтнуудад сургалт, арга зүйн зөвлөгөө өгөх	Архивын арга зүйч	100,000				Архивын баримтад эрдэм шинжилгээ техник боловсруулалт хийх, данс бүртгэл үйлдэх, баримт бичгийн ангилан төрөлжүүлэлт, анхаарах асуудлын талаар нэгдсэн нэг ойлголт өгөх зорилгоор 2017 оны 04 дүгээр сарын 06-ны өдөр нөхөн бүрдүүлэлт хийгдэх 17 цэцэрлэгийн архив, бичиг хэрэг хариуцсан 20 ажилтнуудад 1 удаагийн онол практик хосолсон сургалт зохион байгуулсан.	100
37	Албан хэрэг хөтлөлтийн талаар Засаг даргын Тамгын газар, хороодын зохион байгуулагч, харьяа хэлтсийн мэргэжилтэн, албан хаагчдад Нийслэлийн Архивын газрын албан хэрэг хөтлөлт, архивын үйл ажиллагаанд EDOC программыг нэвтрүүлэх	Архивын арга зүйч, Албан хэрэг хөтлөлт, түүний зохицуулалт хариуцсан ажилтан, Бичээч оператор	200,000				Нийслэлийн Засаг даргын 2017 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн А/252 дугаар захирамж буюу “Албан хэрэг хөтлөлтийн журам”-ын хүрээнд Тамгын газрын албан хаагчид болон хороодод 2017 оны 05 дугаар сарын 25-ны өдөр “АЛБАН ХЭРЭГ ХӨТЛӨЛТИЙН EDOC.UB.GOV.MN” программын талаар сургалт зохион байгуулж 45 албан хаагч хамрагдсан. Сургалтаар баримт бичгийг зохион бүрдүүлэх, хүлээн авах, бүртгэх, шийдвэрлэх үйл ажиллагаанд тоон технологи нэвтрүүлэх, баримт бичигтэй ажиллах талаар мэдлэг олгосон.	100
38	Дүүргийн Засаг даргын Тамгын газрын	Архивын арга зүйч					2017 оны 02 дугаар сарын 09-ний өдөр Нийслэлийн Архивын газрын албан хэрэг хөтлөлт хариуцсан мэргэжилтэн Б.Биндерятай хамтарч Тамгын газрын албан хаагч нарт	100

	ажилтнуудад албан хэрэг хөтлөлтийн талаар сургалт явуулах							“EDOC программын хэрэглээ”-ний талаар сургалт явуулж уг сургалтаар нийт 20 албан хаагч хамрагдаж албан бичгийн шийдвэрлэлт болон, программын талаар онол болон практик хосолсон ойлголт авсан	
39	Дүүргийн архивт сан хөмрөг үүсгэгч байгууллагуудын архив, бичиг хэрэг хариуцсан ажилтнуудын дунд ур чадварын тэмцээн зохион байгуулах	Архивын тасгийн дарга, Архивч, сэлбэн засагч, Албан хэрэг хөтлөлт, түүний зохицуулалт хариуцсан ажилтан	200,000					Хэрэгжээгүй	0
40	Нөхөн бүрдүүлэлтийн төлөвлөгөө, хуваарь, календарчилсан графикийг Тамгын газрын даргаар батлуулж ажиллах	Архивын тасгийн дарга, Архивын арга зүйч						2017 оны 03 дугаар сарын 29-ний өдөр нөхөн бүрдүүлэлтийн эх үүсвэрийн жагсаалтыг батлуулж, үүний дагуу 2017 оны 03 дугаар сарын 30-ны өдөр нөхөн бүрдүүлэлтийн хуваарийг Засаг даргын Тамгын газрын даргаар тус тус батлуулан ажиллаж байна.	100
41	Дүүргийн Засаг даргын дэргэдэх хэлтсүүдийн нөхөн бүрдүүлэлт хийх архив хариуцсан ажилтнуудад зөвлөгөө өгч, хуваарь гаргаж өгөх	Архивын арга зүйч, Архивч, сэлбэн засагч						Архивын сан хөмрөгийг нөхөн бүрдүүлэх үндсэн эх үүсвэрийн жагсаалтад орсон /дэргэдэх байгууллага-3, Нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага-1, цэцэрлэг-18, сургууль-6/ нийт 28 байгууллагын архив, албан хэрэг хөтлөлт хариуцсан мэргэжилтэнүүдэд архивын баримтыг ангилан төрөлжүүлэх, данс бүтгэл хэрхэн үйлдэх талаарх арга зүйн заавар зөвлөгөө тогтмол өгч ажиллаж байна. 2017 оны нөхөн бүрдүүлэлтийн хуваарьт орсон Ерөнхий боловсролын 10, 15, 34, 41, 52, 75, 114 дүгээр сургуулийн үүсэн байгуулагдсанаас хойших 1972-2015 онуудын байнга хадгалах нийт 1413 хадгаламжийн нэгжийг татан авч нөхөн бүрдүүлэлтийн ажлыг хийж гүйцэтгэсэн. Мөн 2016 оны Тамгын газарт хөтлөгдөх хөтлөх хэргийн нэрийн жагсаалтыг 2017 оны	100

							<p>02 дугаар сарын 02-ны өдөр батлуулж, хуваарь гарган хэлтэсүүдээс авсан. Үүнд :</p> <ul style="list-style-type: none"> - байнга хадгалах-101/хн/, - 70 жил хадгалах-11/хн/, - түр хадгалах-143/хн/, <p>тусгай төрлийн-9 /хн/ буюу нийт 264 хадгаламжийн нэгжийг стандартын дагуу архив зүйн үндэслэлтэйгээр баримтын бүрэн бүрдэл бүхий хадгаламжийн нэгж болгон хүлээн авсан. Хан-Уул дүүргийн Архивын 2 дугаар санд хадгалагдаж байсан 2012 оны “УИХ-ын сонгууль”-ийн нийт 155 хадгаламжийн нэгж, 5803 хуудас бүхий баримтыг он цагийн дэс дараалал, хуудасны дугаарлалтыг нэг бүрчлэн хийж, “Бусад баримт” гэсэн нэрээр хадгалсан баримтыг судалж нэр төрлөөр нь ангилан төрөлжүүлж, данс бүртгэлийг шинээр үйлдэж Тамгын даргын гарын үсгээр 2017 оны 11 дүгээр сарын 02-нд батлуулан НАГ-т хүлээлгэн өгч акт хүлээлгэн авсан.</p>	
	хөрөнгийн судалгааг хийнэ.									
98	Яармагийн хороодод хэсэгчилсэн камер суурилуулах ажлыг Цагдаагийн хэлтэстэй хамтран хэрэгжүүлнэ.	Орон нутгийн хөгжил, хөрөнгө оруулалтын төлөвлөлт, хэрэгжилт хариуцсан мэргэжилтэн У.Намуун	50.0						Нийслэлийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө, ААНБ, иргэдийн хөрөнгө оруулалтаар пүүргийн хэмжээнд 184 ширхэг камер ашиглалтад оруулсан байна.	100
99	Камержуулах шаардлагатай сургууль, цэцэрлэг, хүүхдийн тоглоомын талбайн судалгааг гаргана.	Орон нутгийн хөгжил, хөрөнгө оруулалтын төлөвлөлт, хэрэгжилт хариуцсан мэргэжилтэн У.Намуун	20.0						Камержуулах шаардлагатай сургууль цэцэрлэгийн гадна тоглоомын талбайн судалгааг гаргаж, эхний ээлжинд 1, 3, 4, 16 дугаар хороонд нийт 4 сургууль, 2 цэцэрлэгийн тоглоомын талбайг камержуулах шаардлагатай гэсэн судалгаа гаргаад байна.	70
100	Төрийн үйлчилгээний нэг цэгийн төв барих байршлын судалгаа, хэрэгцээний судалгааг гаргана	Орон нутгийн хөгжил, хөрөнгө оруулалтын төлөвлөлт, хэрэгжилт хариуцсан мэргэжилтэн У.Намуун							2018 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгасан. 5 дугаар хороонд байршлыг сонгон, газрын зориулалтыг өөрчлөх захирамжийн төсөлд оруулсан. Зураг төсөв хийх хөрөнгийг батлуулан зураг төсөв хийх бэлтгэл ажил хийгдэж байна.	90
101	Цагдаагийн 1, 2-р хэлтэс, Газрын албатай хамтран цагдаагийн үйлчилгээ шаардлагатай байгаа хэсгүүдийн судалгаа, барих	Орон нутгийн хөгжил, хөрөнгө оруулалтын төлөвлөлт, хэрэгжилт хариуцсан мэргэжилтэн У.Намуун							Цагдаагийн 2 дугаар хэлтсээс хийсэн судалгаагаар тус дүүргийн 12 дугаар хорооны нутаг дэвсгэрт цагдаагийн хэсэг шинээр байгуулах шаардлагатай гэсэн судалгаа гарсан. Үүний дагуу Газрын албатай хамтран боломжтой газрын байршлын судалгааг хийж байна.	70

	боломжтой байршлыг тогтоож зураг төсөл хийлгэх ажлыг эхлүүлнэ.								
102	Дүүргийн Нэгдсэн эмнэлэгт сүүлийн үеийн мэс заслын эмчилгээ, оношилгооны тоног төхөөрөмжтэй тасаг шинээр байгуулна.	Орон нутгийн хөгжил, хөрөнгө оруулалтын төлөвлөлт, хэрэгжилт хариуцсан мэргэжилтэн У.Намуун	666.7					Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар Хан-Уул дүүргийн Нэгдсэн эмнэлэгт 661 000 000 төгрөгөөр мэс заслын тасаг байгуулахаар цахим тендер Нийслэлийн Эрүүл мэндийн газарт 2017 оны 03 дугаар сарын 27-ны өдөр зарлагдсан. Гүйцэтгэгч нь шалгарсан бөгөөд ажил гэрээ байгуулагдан хийгдэж дуусаад байна. Дүүргийн төсвийн хөрөнгөөр ЭМТ-ийн шүдний кабинетэд шүдний бор машин авсан. ЗДТГ-ын “Ахмадаа дээдэлье” хөтөлбөрийн хүрээнд Автомат даралтын аппарат 1 ширхэг, Өвчтөний тэргэнцэр 1 ширхэг, Өөх, булчин хэмжигч аппарат 1 ширхэг, Зайнаас халуун хэмжигч 1 ширхэг, Сахар хэмжигч 1 ширхэг, Пульсоксиметр 1 ширхэг, Жин болон өндөр хэмжигч 1 ширхэгийг авсан. ЗДТГ-ын “Аз жаргалтай гэр бүл” хөтөлбөрийн хүрээнд доплер 5 ширхэг, эмэгтэйчүүдийн үзлэгийн ор 1 ширхэгийг тус тус нийлүүлсэн.	100
103	Хот суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуулийн дагуу 2016 оны 7 сард шинэчлэн батлагдсан Ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны барилгыг дахин төлөвлөх үйл ажиллагааны журмын	Төсөл хөтөлбөр, индекс, гэр хорооллын дэд бүтэц хариуцсан мэргэжилтэн	5.0					Нийслэлийн Хот төлөвлөлт, ерөнхий төлөвлөгөөний газартай хамтран орон сууц бүхий 2, 3 ,10, 11 дүгээр хороодын иргэд, оршин суугчдад ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцнуудын дахин төлөвлөлтийн ажлын явц болон цаашдын зорилт болон журмын талаар танилцуулга уулзалтыг 3 удаа хийсэн бөгөөд 2017-03-17-ны өдөр Барилга, хот байгуулалтын сайд Г.Мөнхбаяр болон албаны холбогдох хүмүүс дахин барилгажуулах төсөлд хамрагдсан орон сууцнуудын иргэд, төсөл гүйцэтгэгч компаниудын төлөөлөлтэй уулзалт-ярилцлага хийх ажлыг зохион байгуулан ажилласан . ХТЕТГ-т үнэлгээний хороонд 2, 3, 11 дүгээр хороодын оршин суугчдыг төлөөлөн ажиллах иргэдийн нэрсийг 4 удаа хүргүүлж 5 дугаар сарын 9-ны өдөр Сүхбаатарын талбайд зохион байгуулагдсан НХТЕТГ-ын	100

	танилцуулга, хэлэлцүүлгийг зохион байгуулна.							Нээлттэй хаалганы өдөрлөгийн арга хэмжээнд төвийн бүсийн хороодын 40 гаруй иргэд, оршин суугчдыг оролцуулав. Ашиглалтын шаардлага хангахгүй орон сууцнуудыг дахин төлөвлөх ажлын хүрээнд 2, 3, 10, 11 дүгээр хорооны 31 байрыг дахин барилгажуулахаар нийслэлийн Ерөнхий төлөвлөгөөний газраас хэрэгжүүлж байгаа 11 багцын дахин төлөвлөлт болон гэр хорооллын дахин төлөвлөлтийн хэрэгжилтийн талаар Power point программ дээр албан хэрэгцээнд зориулан танилцуулга бэлтгэж, мэдээллийн сан бүрдүүлсэн. 2017 оны байдлаар ашиглалтын шаардлага хангахгүй дахин төлөвлөлтөнд хамрагдах нийт 11 багцын 31 орон сууцнаас төслийн гүйцэтгэгч тодорсон / Нутгийн буян, Эфэс, Фужи холдинг ХХК, Эм Эм Жи Капитал ХХК, ОХС ХХК, / 5 багцын 18 орон сууц байгаа ба үүнээс 3 орон сууц баригдсан ба 4 барилгын ажил эхлээд байна.	
104	Газар өмчлөгч эзэмшигч иргэдийн дунд дахин төлөвлөлтийн үйл ажиллагааг эрчимжүүлэн, “Зөв шийдэлтэй” дахин төлөвлөлтийн үзэл санааг олон нийтэд хүргэх ажлыг хэрэгжүүлнэ.	Төсөл хөтөлбөр, индекс, гэр хорооллын дэд бүтэц хариуцсан мэргэжилтэн	5.0					Гэр хорооллын газрыг шинэчлэн зохион байгуулах төслийн ажлын талаар иргэдээс бичгээр, утсаар болон амаар 12 санал хүсэлт хүлээн авч, хариу өгсөн. Түүнчлэн Яармагийн 5 дугаар хорооны арьс ширний 80 айлын 9, 10, 11, 12 дугаар нийтийн байруудыг дахин төлөвлөлтөнд оруулах ажлыг иргэдийн оролцоотойгоор эхлүүлсэн. Эхний ээлжинд 10 дугаар байрыг буулган 2 давхар 40 айлын орон сууцыг барих ажлыг “Нью Биг Фиш Констракшн” ХХК гүйцэтгэж, 2018 оны 2 дугаар улиралд ашиглалтад оруулахаар ажиллаж байна.	100
105	Гэр хорооллын дахин төлөвлөлтийн суурь судалгаанд суурилан хэсэгчилсэн инженерийн дэд бүтэцтэй болох	Төсөл хөтөлбөр, индекс, гэр хорооллын дэд бүтэц хариуцсан мэргэжилтэн	24.0					Нийслэлийн Гэр хорооллын дэд бүтцийн газраас дүүргүүдийн гэр хорооллын айл өрхийн дунд 2017 оноос эхлэн дэд бүтцийн төв байгуулах ажлыг эхэлсэнтэй холбогдуулан бага оврийн цэвэрлэх байгууламж хийх шаардлагагүй гэж үзээд тухайн хөрөнгийг дүүргийн тохижилт, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх ажилд зарцуулахаар шийдвэрлэсэн. 2017 онд 9 дүгээр хорооны Буянт-Ухаагийн 23 дугаар гудамжаас Бурхантын 17 дугаар гудамжны 250-300 гаруй өрхүүдийг	100

	иргэдийн санал санаачлагыг дэмжин 4-5 бага оврын цэвэрлэх байгууламжийг иргэдийн оролцоотой хийж гүйцэтгэнэ.							хамруулан энэхүү дэд бүтцийн төв буюу сервис центр байгуулах ажил эхлээд байна. Нийслэлийн ХТЕТГ-аас зарласан сонгон шалгаруулалтаар Пальм дейра ХХК зураг төслийн гүйцэтгэгчээр шалгарсан ба Нийслэлийн хөрөнгө оруулалтын газартай гэрээ байгуулан ажлаа эхлээд байна.	
106	Дүүргийн суурьшлийн бүс, нийтийн эзэмшлийн газрын зам талбайд орчин үеийн архитектор, дизайны шийдлийг боловсруулж хэрэгжүүлэх ажлын бүтэц гарган зардлыг батлуулна.	Төсөл хөтөлбөр, индекс, гэр хорооллын дэд бүтэц хариуцсан мэргэжилтэн	48.0					Нийслэл, дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл, арга хэмжээ бага байсан тул гэрээтээр 1 архитектор ажиллуулж байна.	50
107	ЗДТГ болон ЗД-ын дэргэдэх хэлтэс, албадын дарга нарт албан хаагчдын ажлын үр дүнг КPI-ээр үнэлэх аргачлалын талаар судалж, сургалт зохион байгуулах	Гүйцэтгэлийн хяналт, шинжилгээ хариуцсан мэргэжилтэн Н.Алдармаа	1.0					ЗГ-ын 2017 оны А89 дүгээр тогтоолоор батлагдсан журам болон НЗД-ын 2017 оны А/335 дугаар захирамжаар батлагдсан журмын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд “Бодлогын баримт боловсруулах, санал өгөх, тайлагнах арга зүй”, “Байгууллагын үйл ажиллагааны тайлан боловсруулах арга зүй” сэдэвт сургалтыг Сангийн яамны мэргэжилтэн С.Мөнгөнцацрал, НЗДТГ-ын БТХ-ийн мэргэжилтэн Б.Бадамжав, ХШҮХ-ийн мэргэжилтэн Б.Эрдэнэ-Оюун нартай хамтран Засаг даргын Тамгын газар болон Засаг даргын дэргэдэх хэлтэс, албадын 42 албан хаагчдыг хамруулан 2017.09.15-ны өдөр зохион байгуулсан.	100
108	Хөрөнгө оруулалт,	Орон нутгийн	4.0					Хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын ажлын явц цаашид	100

	төлөвлөлтийн талаарх танилцуулах материал хороодод тараах, сургалт сурталчилгаа хийнэ.	хөгжил, хөрөнгө оруулалтын төлөвлөлт, хэрэгжилт хариуцсан мэргэжилтэн У.Намуун						төлөвлөсөн ажлуудын талаар тараах материал хэвлүүлэн 2017.11.11-ний өдөр нэг цэгээр төрийн үйлчилгээ үзүүлэх ажлаар 12, 13, 14 дугаар хороодод ажиллаж, 2017 онд улс, нийслэл, дүүрэг, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хийгдэж байгаа ажлын талаар иргэдэд танилцуулга, мэдээлэл хийж ажиллав.	
109	“Аз жаргалтай хот” хөтөлбөрийг дүүргийн нутаг дэвсгэрт зохион байгуулж, биелэлтийг улирал тутам гарган хүргүүлж ажиллана.	Төсөл хөтөлбөр, индекс, гэр хорооллын дэд бүтэц хариуцсан мэргэжилтэн						Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны “Аз жаргалтай хот” хөтөлбөрийг дүүргийнхээ нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулан нийслэлийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлээс үр дүнгийн гэрээний хавсралтаар хариуцан хэрэгжүүлэхээр тусгасан 66 арга хэмжээний биелэлтийг улирал бүр гарган Нийслэлийн Засаг даргын Хяналт, шинжилгээ үнэлгээний хэлтэст хүргүүлэн ажилласан. Жилийн эцсийн байдлаар 91,1 хувьтай хэрэгжсэн биелэлтийг НЗДТГ-ын Хяналт, шинжилгээ-үнэлгээний хэлтэст 2017 оны 12 сарын 18-ны өдрийн 04/2235 тоот албан бичгээр хүргүүлэн ажилласан.	100
110	Дүүрэгт хэрэгжиж буй төсөл хөтөлбөрийн биелэлтийг сайжруулах, холбогдох газруудаас мэдээ мэдээлэл авч хамтран ажиллана.	Төсөл хөтөлбөр, индекс, гэр хорооллын дэд бүтэц хариуцсан мэргэжилтэн						Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 онд шинээр боловсруулах болон үргэлжлүүлэн хэрэгжүүлэх Үндэсний хөтөлбөрийн жагсаалтыг гарган дүүргийн сайтад байршуулсан. Дүүргийн Засаг даргын 2017-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн “Зөв хүүхэд-Зөв ирээдүй”, “Ахмадаа дээдлэе”, “Аз жаргалтай гэр бүл” дэд хөтөлбөрийг боловсруулан Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Тэргүүлэгчдийн хурлаар хэлэлцүүлэн батлуулсан бөгөөд жилийн эцсийн байдлаар үндэсний 31, нийслэлийн 20 дэд хөтөлбөр, дүүргийн 4 дэд хөтөлбөрийн биелэлтийг хариуцан хэрэгжүүлж буй хэлтэс, албадаас авч холбогдох яам, агентлаг, нийслэлд хүргүүлэхээр ажиллаж байна.	100
36 АЖЛЫН БИЕЛЭЛТ 84.8 ХУВЬТАЙ ХЭРЭГЖСЭН									

ДӨРӨВ. ХҮНС, ХУДАЛДАА ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХЭЛТЭС

111	Хүнс, хөдөө аж ахуй, зочлох үйлчилгээ, худалдаа, хоол үйлдвэрлэл, үйлчилгээ, авто үйлчилгээний салбарт ажиллагсдын дунд сургалт, семинар, үзүүлэх сургууль, тэмцээн уралдааныг мэргэжлийн байгууллагуудтай хамтран зохион байгуулж олон нийтэд түгээнэ.	Хүнс, худалдаа, үйлчилгээний хэлтэс	30322.0				Хүнс, хөдөө аж ахуй, зочлох үйлчилгээ, худалдаа, хоол үйлдвэрлэл, үйлчилгээ, авто үйлчилгээний салбарт ажиллагсад, хороодын албан хаагчид, хэсгийн ахлагч, иргэд, аж ахуйн нэгж, байгууллага, малчин тариаланчдад 2017 онд 17 удаагийн сургалт, уулзалт, хэлэлцүүлгийг холбогдох хэлтэс албад, төрийн бус байгууллагатай хамтран зохион байгуулж, давхардсан тоогоор 1164 гаруй иргэн, ААНБ хамрагдлаа.	100
112	Хүнс, хөдөө аж ахуй, жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн бүтээгдэхүүн үйлчилгээг сурталчлах, дэмжлэг үзүүлэх, борлуулалтыг дэмжих ажлыг зохион байгуулна.	Хүнс, худалдаа, үйлчилгээний хэлтэс	11996.0				Хөдөө аж ахуй, жижиг дунд үйлдвэрлэл, хоол үйлдвэрлэл, худалдаа үйлчилгээ эрхлэгчдийн бүтээгдэхүүн үйлчилгээг сурталчлах, дэмжлэг үзүүлэх, борлуулалтыг дэмжих ажлыг зохион байгуулах ажлын хүрээнд шинэ жил, сар шинийн баяр, авто машингүй өдөр, “Шөнийн гудамж” зэрэг Нийслэл, дүүргээс зохион байгуулсан соёл урлаг, спорт, олон нийтийн 10 удаагийн арга хэмжээнд 214 иргэн, ААНБ-ын бүтээгдэхүүн, үйлчилгээг сурталчлан, борлуулалтыг дэмжин иргэдэд цагаан идээ, мах махан бүтээгдэхүүн, халуун хоол, ундаа, торт нарийн боов, хагас боловсруулсан бүтээгдэхүүн, зайрмаг, бэлэг дурсгалын зүйлсээр үйлчиллээ.	100
113	Худалдаа, хоол үйлдвэрлэл, ахуйн үйлчилгээ, аялал	Хүнс, худалдаа, үйлчилгээний хэлтэс	3118.0				Дүүргийн нутаг дэвсгэрт худалдаа, хоол үйлдвэрлэл, үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй иргэн, ААНБ-д хүнсний аюулгүй байдал болон холбогдох хууль,	100

	жуулчлал, авто үйлчилгээний цэгүүдийн үйл ажиллагаанд холбогдох хэлтсүүдтэй хамтран хяналт, шалгалт зохион байгуулж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгнө.							тогтоомж, стандартын хэрэгжилтийг хангуулах үүднээс МХХ, ЦХ, НЗАА зэрэг холбогдох мэргэжлийн байгууллагуудтай хамтран нийт 18 удаагийн хяналт шалгалт зохион байгуулж 621 иргэн аж ахуй, нэгжийг хамруулж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллаа.	
114	Газар тариалангийн үйлдвэрлэл эрхэлж буй иргэн, аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, мэдээ судалгааг бодит болгох, шинэчлэх, мэдээлэл арга зүйгээр хангана.	Хүнс, хөдөө аж ахуй хариуцсан мэргэжилтэн Л.Саруултуяа	3000.0					Дүүргийн нутаг дэвсгэрт төмс, хүнсний ногоо тариалдаг иргэн аж ахуйн нэгж байгууллагын судалгааг шинэчлэн гаргасан. Үүнд :• Ногоо тарьдаг өрх -498• Аж ахуйн нэгж байгууллага, хоршоо- 32 байна.2017 онд нийт 242,3 га талбайд тариалалт хийхээс 12 га-д малын тэжээл, 20,6 га-д төмс, 209,9 га-д хүнсний ногоо,жимсгэнэ тариалж, 60тн малын тэжээл, 310 тн төмс, 2514 тн хүнсний ногоо тус тус хураан авах зорилт тавин, хаврын тариалалтын бэлтгэл ажил хийгдэж байна.Өрхийн төмс, хүнсний ногооны тариалалт, хэрэглээг нэмэгдүүлэх зорилгоор төмс, хүнсний ногоо тариалах сонирхолтой 4,5,6,7,8,9,10,12,13,14 дүгээр хорооны 500 өрхөд 2,5 тонн төмс, 5 кг шар манжин, 5 кг хүрэн манжин, 60 кг сонгины үрийг хороодоор дамжуулан тарааж, ногоочин өрхүүдэд дэмжлэг үзүүлэн, тариалалтыг дэмжин ажиллаа. ХХААХҮЯ, Нийслэлийн Хүнс, хөдөө аж ахуйн газартай хамтран Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн сайдын 2015 оны А/105 тоот тушаалаар баталсан “Ургамал түүний гаралтай хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний ул мөрийг мөрдөн тогтоох бүртгэлийн журам”-ын хэрэгжилтийн хүрээнд зах зээлд борлуулах ургамал, түүний гаралтай хүнсний эд, бүтээгдэхүүний гарал үүслийн гэрчилгээ, тариаланч иргэний баталгааны тэмдэг олгох ажлын талаар танилцуулах, иргэдийн санал хүсэлтийг сонсож, хариулт өгөх сургалт,	100

								уулзалтыг 12,13,14 дүгээр хорооны 100 гаруй ногоочдод зохион байгуулсан.“Монгол ногоо” төсөлтэй хамтран бага орлоготой, хашаандаа төмс, хүнсний ногоо тарих сонирхолтой иргэдэд цогц мэдлэг олгох 3 үе шаттай сургалтыг зохион байгуулах бөгөөд эхний шатны сургалт буюу хүнсний ногооны эрүүл мэндийн ач холбогдол, талбайн төлөвлөлт үр ашиг, ногоо тарих арга технологи” эзэмших онол, дадлагын сургалтыг зохион байгуулсан. Сургалтад 4,5,6,7,8,9,12,13,14 дүгээр хорооны 65 иргэн хамрагдсан.Мөн дүүргийн сургууль цэцэрлэгийн тогооч нарт хоол тэжээлийн сургалтыг 13 дугаар хороо болон 34-р сургууль дээр 2 удаа зохион байгуулсан. Сургалтад зорилтод 5 сургуулийн 5, 2 цэцэрлэг-2, бусад сургууль цэцэрлэгийн 45 нийт 52 тогооч нар хамрагдсан.	
115	Дүүргийн мал сүргийг халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах, гэрээт мал эмнэлгүүдэд үйлчилгээний зардал олгох, хэрэгжилтэд холбогдох мэргэжлийн байгууллагуудтай хамтран хяналт тавьж ажиллана.	Хүнс, хөдөө аж ахуй хариуцсан мэргэжилтэн Л.Саруултуяа	25000.0					Дүүргийн Засаг даргын А/109 дугаар захирамжаар дүүргийн нутаг дэвсгэр дэх мал амьтанд 2017 онд хийх мал эмнэлгийн үйлчилгээ үзүүлэх төлөвлөгөө, мал амьтны хашаа байранд ариутгал халдваргүйтгэл хийх төлөвлөгөөг тус тус баталж, шаардагдах зардалд Засаг даргын Тамгын газрын батлагдсан төсвөөс 6 дугаар сарын байдлаар 9,0 сая төгрөгийг гэрээт 3 мал эмнэлэгт олгосон байна.Нийт 7 төрлийн вакциныг давхардсан тоогоор 30950 толгой мал, 11000 гахай, 67000 шувуу нийт 108950 мал амьтанд, мал амьтны хашаа саравч, тоног хэрэгсэл, агуулах, зоорь, түүхий эд хадгалах, бэлтгэх газар, худалдааны төвүүдийг хамруулж 39570 м2 талбайд ариутгал халдваргүйжүүлэлт хийж, 558 үхсэн малын сэг зэмийг чөтгөрийн хонхор, био комбинатын хогийн цэг, гавжийн шандын задгай гэх устгалын цэгт булшлан, ариутгал халдваргүйжүүлэлтийг хийсэн.	100

116	Хүүхэд залуучууд, ахмад настанд чиглэсэн танин мэдэхүйн аялал зохион байгуулна.	Хоол үйлдвэрлэл аялал жуулчлал хариуцсан мэргэжилтэн Б.Нарантуяа	2676.0				Дүүргийн ЕБС-ийн сурагчдад үйлдвэр, аж ахуйн газрын үйл ажиллагаатай танилцах “Өртөөчилсөн аялал”-ыг зохион байгуулж, ерөнхий боловсролын 15 сургуулийн 90 гаруй сурагчид оролцлоо. Үйлдвэр, аж ахуйн газрын үйл ажиллагаатай танилцах “Өртөөчилсөн аялал”-аар тухайн аж ахуйн нэгжтэй танилцаад зогсохгүй сурагчдад экологийн боловсрол олгох үүднээс усаа хэрхэн хэмнэх, байгаль дэлхийгээ хайрлан хамгаалах талаар танин мэдэхүйн хичээл орж, нийслэл, дүүргийн бүтээн байгуулалт, шилдэг аж ахуйн нэгжүүдтэй танилцсан юм. Аялалаар “Ус сувгийн удирдах газар”-ын сургалтын төвийн музей, “Чингис хаан вакс баримлын музей”, “Цэнгэг усны нөөц, байгаль хамгаалах төв”-ийн музей, аквариум, “Мөнхийн үсэг групп” ХХК-ийн хэвлэлийн үйлдвэр, “Аз хур” номын дэлгүүр, Зайсан дахь “KFC” түргэн хоолны газар, “Атар өргөө” ХК-ийн талхны үйлдвэр, “Улаанбаатар хивс” ХК, “Говь” ХК, “Жи Эн Бевережис” ХХК-ийн Pepsi ундааны үйлдвэрийн үйл ажиллагаатай танилцаж, “Азхур” номын их дэлгүүрт зочилж, залуу зохиолч н.Мөнхтэгштэй уулзалт хийлээ.	100
117	Хөнгөлөлттэй зээл, төсөл хөтөлбөр, зээлийн батлан даалтын сангийн дэмжлэг, ноос арьс ширний урамшуулалд хамруулах ажлыг зохион байгуулна.	Хүнс, хөдөө аж ахуй хариуцсан мэргэжилтэн Л.Саруултуяа, Үйлдвэрлэл инноваци хариуцсан мэргэжилтэн О.Ану-Дарь	0.0				Швейцарийн хөгжлийн агентлагийн санхүүжилтээр хэрэгжиж буй “Монгол ногоо” төсөл нь өрхийн тариалан эрхлэгч иргэдийг дэмжих, төмс, хүнсний ногооны үйлдвэрлэл, хэрэглээг өрхийн хүнсний ногооны тариалалтаар нэмэгдүүлэх аж ахуй эрхлэх, ур чадвар эзэмшүүлэх зорилготойгоор 2016-2019 он хүртэл хэрэгжиж байна. Уг төсөлд 13 дугаар хорооны 26, 10 дугаар хорооны 22 өрх, 5,9,13 дугаар хороодод загвар өрх 3, нийт 53 өрх, 71 дүгээр цэцэрлэг, 34 дүгээр сургууль, 10 дугаар сургуулиуд дээр төсөл хэрэгжиж байна. Сонгогдсон өрх болон сургуулиудад гар багаж, үр үрсэлгээ болон хүлэмжийн дэмжлэг үзүүлсэн. Мөн жишиг гудамжны өрхүүдэд ногоо услах зориулалт бүхий гүн өрмийн 2 худгийг гаргасан. Худгийн зардлын 20% буюу орон нутгийн оролцооны 5.000.0 /таван сая/ төгрөгийг ЗДТГ-аас гаргасан. НҮБ-ын ХХААБ-ын хамтран	100

								малчин өрхийн амьжиргааг дэмжих зорилгоор 30 фермерт хорголжин тэжээл, малын витамин, хужир үнэгүй олгосон. ХХААХҮЯ-аас газар тариалан эрхлэгчдийг дэмжих, хүлэмжийн аж ахуйг нэмэгдүүлэх чиглэлээр нийлэг хальсан хүлэмжийг хүүгүй, зээлээр олгосон. Зээлэнд 12 иргэн хамрагдаж 16 сая төгрөгийн үнэ бүхий хүлэмжийн зээлэнд хамрагдсан. Арьс ширний урамшуулалд-31, ноосны урамшуулалд- 13 малчныг хамруулсан.	
118	Тамхи худалдаалах тусгай зөвшөөрлийг хуулийн дагуу олгох, холбогдох хууль тогтоомж, стандартыг мөрдүүлэх, хариуцсан салбарын хүрээнд хамтран ажиллах гэрээ байгуулна.	Хүнс, худалдаа, үйлчилгээний хэлтсийн мэргэжилтнүүд						2017 онд дүүргийн Засаг даргын 7 удаагийн захирамжаар 80 иргэн, аж ахуйн нэгжид тамхи худалдах тусгай зөвшөөрөл олгож, 20.400.000 сая төгрөг,салбарын хууль тогтоомж, стандартыг мөрдүүлэх үүднээс худалдааны чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй 311, хоол үйлдвэрлэлийн 177, Аялал жуулчлалын 23, ахуйн үйлчилгээний 44, жижиг, дунд үйлдвэрлэлийн 35, авто засвар, үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй 19, нийт 609 иргэн, аж ахуйн нэгжтэй хамтран ажиллах гэрээ байгуулан, гэрчилгээ олгож, 6.090.000 төгрөгийн тэмдэгтийн хураамжийг тус тус дүүргийн төсөвт тус тус төвлөрүүлсэн байна.	100
8 АЖЛЫН БИЕЛЭЛТ 100% ХЭРЭГЖСЭН									
ТАВ. ТОХИЖИЛТ, НИЙТИЙН АЖ АХУЙН ХЭЛТЭС									
119	Нийтийн эзэмшлийн зам талбайг цардмалжуулах, чулуун хучилт хийх ажил	ТНААХ, СӨХ, тохижилт, гэрэлтүүлэг хариуцсан мэргэжилтэн	Дүүргийн хөрөнгө оруулалт 50 сая.т					Дүүргийн 16 хорооноос авсан судалгаагаар нийтийн эзэмшил болон орон сууц, гэр хороолол дундах зам талбайг цардмалжуулах, хатуу хучилттай болгох боломжтой 88730м2 бүхий талбай байна. 2018 онд гэр хорооллын орчинд хийгдэх тохижилт, зам талбайн цардмалжуулах тохижилтын ажлын саналыг Нийслэлийн Захирагчийн ажлын албанд хүргүүлсэн. Энэхүү ажлын хүрээнд ХУД-ийн Яармаг эрүүл мэндийн төвийн гадна талбайн тохижилтын зураг төслийг хийлгэн	100

							<p>Нийслэлийн төсвийн урсгал зардлаас төсвийг гаргуулахаар шийдвэрлэсэн.</p> <p>1. Дүүргийн хөрөнгө оруулалтаар 5 дугаар хорооны Өрхийн эмнэлэг, 5 дугаар хорооноос 145 дугаар цэцэрлэг хүртэлх явган хүний зам, тохижилтын ажлыг “Талын хүч ХХК” 50 сая төгрөгөөр хийж гүйцэтгэсэн.</p> <p>2. Нийслэлийн хөрөнгө оруулалтаар МИАТ ХК-ны спорт заалны уулзвараас хойш 34 дүгээр байрны баруун тал, 10 дугаар хороо Нисэхийн 3 дугаар гудамжны 342 дугаар худаг хүртэл шороон замыг 30.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар түрж тэгшлэн сайжруулсан.</p> <p>3. 10 дугаар хороо 63 дугаар байрны явган зам, авто зам засварлах, цардмалжуулах ажил 20.0 сая төгрөгийн хөрөнгөөр хийгдсэн.</p>	
120	<p>Тухайн жилийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний дагуу нөхөн сэргээлтийн ажлыг гүйцэтгүүлж, нөхөн сэргээлтийн тайланг холбогдох эрх бүхий байгууллагад цаг тухайд нь хүргүүлж ажиллах</p>	<p>ДБТХ, Байгаль орчин, ногоон байгууламж хариуцсан мэргэжилтэн Ю.Энхтунгалаг</p>					<p>Дүүргийн нутаг дэвсгэрт түгээмэл тархацтай ашигт малтмалын ашиглалтын болон хайгуулын тусгай зөвшөөрөлтэй 84 аж ахуйн нэгж, байгууллага олборлолт хийж байна.</p> <p>Дүүргийн Засаг даргын 2017 оны А/52, А/193, А/332 дугаар захиражмийн дагуу түгээмэл тархацтай ашигт малтмалын олборлолтын үйл ажиллагаа эрхэлж байгаа 43 ААНБ-иудад хяналт шалгалтыг 11 удаа хийж гүйцэтгэсэн.</p> <p>Дүүргийн Засаг даргын А/67, А/80, А/93, А/243, А/256 дугаар захирамжаар хүнд даацын тээврийн хэрэгслэлийн тээвэрлэлтийг түр зогсоох захирамжийн дагуу Цагдаагийн 2 дугаар хэлтсийн албан хаагчид болон, Замын Цагдаагийн хэлтсийн албан хаагчид 14 дүгээр хорооны нутаг дэвсгэрт байрлах Өлзийтийн шалган нэвтрүүлэх товчоо, 12 дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлах Биокомбинат дахь түр пост, морингийн давааны постуудад 3 ээлжээр 24 цагаар 2017 оны 04 дүгээр сарын 15-наас 10 дугаар сарын 15-н хүртэл 6 сарын</p>	100

							<p>хугацаанд ажиллаж, зөрчил гаргасан 194 иргэн, тээврийн хэрэгсэлд 19,200,000 мянган төгрөгийн торгуулийн арга хэмжээ авсан байна.</p> <p>Хан-Уул дүүргийн 12,13, 14 дүгээр хорооны нутаг дэвсгэр Туул голын сав газар, “Гишүүний ам”, “Бөхөгийн хөндий”-д түгээмэл тархацтай ашигт малтмал ашиглах тусгай зөвшөөрөлтэй 67 аж ахуйн нэгжээс 43-н аж ахуйн нэгж, байгууллага хяналт шалгалтад хамрагдсан.</p> <p>Нийслэлийн Засаг даргын 2017 оны 08 сарын 21-ний өдрийн А/609 дугаар захирамжаар ашиглалтын тусгай зөвшөөрөл олгосноос хойш 3 жил үйл ажиллагаа явуулаагүй, газрын хэвлий ашиглах эрх нь дуусгавар болсон 54 аж ахуйн нэгж, байгууллагын тусгай зөвшөөрлийг цуцалсан. Нөхөн сэргээлт хийсэн байдал: Ашиглалтын тусгай зөвшөөрөл нь цуцлагдаагүй аж ахуйн нэгж, байгууллагууд нь техникийн нөхөн сэргээлтийг Боржгоны тал ХХК- 1,45 га талбайд, Минжийн хангайн төгөл ХХК-3,31 га талбайд, Эн Эс АР ХХК-4,1 га талбайд, Гантиг-Уул ХХК-5 га талбайд, Ядам-Од ХХК-2 га талбайд, Мандах Булаг ХХК дүйцүүлэх хамгаалалтын арга хэмжээ авч 4 га талбайд, Өвөрхарзат ХХК-0,3 га талбайд, Гравел стоун ХХК, Сигмабетта ХХК-0,8 га талбайд, Эсто ХХК-0,8 га талбайд, Эслэт ХХК-0,7 га талбай нийт 21,76 га талбайд техникийн нөхөн сэргээлт хийсэн байна.</p>	
121	Бүх нийтээр мод тарих ажлыг 2 удаа зохион байгуулж дүүргийн ногоон байгууламжийг нэмэгдүүлнэ	ТНААХ, Байгаль орчин, ногоон байгууламж хариуцсан мэргэжилтэн Ю.Энхтунгалаг	20.0 сая Хэлтсийн төсөв				<p>“Бүх нийтээр мод тарих Үндэсний өдөр”-ийн хүрээнд ЭКО-ДҮҮРЭГ НОГООН СУРГУУЛЬ, ЦЭЦЭРЛЭГ уриан дор дүүргийн ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, байгаль орчныг нөхөн сэргээх, байгаль орчноо хамгаалах үйлсэд хүн бүрийн оролцоог нэмэгдүүлэх зорилгоор мод, бут сөөг тарих ажлыг зохион байгуулсан.</p> <p>Бүх нийтээр мод тарих” ажлын хүрээнд Засаг даргын Тамгын газар болон дэргэдэх хэлтэс албадын албан хаагчид 2017</p>	100

							оны 5,10 дугаар саруудад 2,3 дугаар хорооны орон сууцны дундах талбай болон 7, 26, 41, 52, 59 дүгээр сургуулиуд,165 дугаар цэцэрлэгийн хашаанд, 6 дугаар хорооны Яармаг-Эрүүл мэндийн төв зэрэг газруудад 10 төрлийн 7035 ширхэг мод, бут сөөгийг тарьж, арчлалт хамгаалалт, намрын цэнэг усалгааг сургууль, цэцэрлэг гүйцэтгэж Хорооны хөгжил, төрийн үйлчилгээ хөтөлбөр болон хэлтсийн төсвөөс 33,114,800 /гучин гурван сая нэг зуун арван дөрвөн мянга найман зуу/ төгрөгийг зарцуулж ажилласан. Бүх нийтээр мод тарих ажлын хүрээнд 917 өрх, 231 аж ахуй нэгж, байгууллага оролцож 3776 иргэдийн оролцоотойгоор нийт 36320 ширхэг мод бут сөөгийг тарьсан байна.	
122	Харшлын өвчин үүсгэгч ургамлыг устгах, тоосонцрын дэгдэлтийг бууруулах арга хэмжээ авна.	ТНААХ, Байгаль орчин, ногоон байгууламж хариуцсан мэргэжилтэн Ю.Энхтунгалаг	10.0 сая Хэлтсийн төсөв				“Хөл газрын ургамал устгах ажлын” хүрээнд “Шарилжгүй Улаанбаатар-1, 2 ” аяны хүрээнд дагуу дүүргийн нутаг дэвсгэрт ургамалын харшлаас сэргийлэх зорилгоор 2017 оны 06 дугаар сараас эхлэн 9 дүгээр сарыг дуустал зэрлэг ургамал устгах ажлыг шат дараалалтайгаар зохион байгуулж ажилласан. Дүүргийн ТҮТ-ОНӨААТҮГ-ийн ногоон байгууламжийн ажилчид нь хариуцсан талбай болох То ван, Шаравын гудамж, 5 бичил цэцэрлэг, 120 мянгат, Төр тогтохын гудамжны ногоон байгууламж, түүний арчилгаа, тордолгоо, усалгаа мөн орон сууцны дунд ургасан зэрлэг ургамал, шарилжийг тогтмол зулгааж устгаж ажилласан.Зэрлэг ургамал устгах ажлын хүрээнд нийт – 514300 м2 талбайг хамруулан цэвэрлэж, 41 рейсээр 82,5 тонн хөл газрын ургамал болон 1,5 тонн түүвэр хогийн ачиж тээвэрлэх ажлыг хийж гүйцэтгэсэн.	100
123	Орон сууцны болон гэр хорооллын нийтийн эзэмшлийн талбайг амралт, чөлөөт	ТНААХ, Байгаль орчин, ногоон байгууламж хариуцсан мэргэжилтэн					Дүүргийн Засаг даргын үйл ажиллагааны үндсэн чиглэлд заасны дагуу нийтийн эзэмшлийн болон орон сууцны дундах зам талбайг зүлэгжүүлж, ногоон байгууламжийг нэмэгдүүлж, өнгө үзэмжтэй цэвэр цэмцгэр, эрүүл таатай орчинг бүрдүүлж Эко-Дүүрэг болгох зорилт тавин ажиллаж байна.	100

	цаг, спортын зориулалтаар тохижуулж,ногоон байгууламжийг нэмэгдүүлнэ.	Ю.Энхтунгалаг						<p>То вангийн гудамж, Төр тогтохын гудамж, Соёлын ордоны урд талын талбай, Шинэ Хан-Уул цэцэрлэгт хүрээлэнгийн ногоон байгууламжийн 80800 м2 талбайг арчлан хөрс боловсруулалт хийсэн.</p> <p>ХУД-ийн 2,3 дугаар хорооны нийтийн эзэмшлийн төв зам дагуу 16800 м2 ногоон байгууламжийн талбайд шинээр зүлэгжүүлэлт хийсэн.</p> <p>Ногоон байгууламжийн арчилгаа тордолгоог хийж хавар, намрын цэнэг усалгааг тогтмол хийсэн. Дүүргийн сургууль, цэцэрлэг, Төв цэнгэлдэх хүрээлэнгийн орчимд ургасан улиас нийт 1600 ширхэг мод, бут сөөгийг хэлбэржүүлсэн. Мод тайралтаас гарсан 380 м3 модны хог болон зүлэгт талбайн хог хаягдлыг 152 рейсээр ачиж тээвэрлэх ажлыг хийж гүйцэтгээд байна.</p> <p>Дүүргийн 2 дугаар хорооны 21,22 дугаар байрны дунд зүлэгжүүлэлт хийж, цэцгийн мандлын талбайд хөрс боловсруулалтын ажлыг технологийн дагуу хийж гүйцэтгэн нийт 1800 ширхэг цэцгийг тарьж үрслүүлж ургуулсан.</p> <p>Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албатай 2017 оны 04-р сарын 07- ний өдрийн 17/06-62 тоот гэрээ байгуулж төвийн бүсийн 1, 2, 3, 11, 15 дугаар хорооны нийтийн эзэмшлийн болон орон сууцны дундах зам талбай, Энхтайвны гүүрний урд талын баруун зүүн тохойны зам, Дунд голын гудамж, Үйлдвэрийн гудамж, Махатма Гандийн гудамжны нийт 949400 м2 талбайн цэвэрлэгээг тогтмол хийсэн байна.</p>	
124	11,12,13, 14 дугаар хорооны цахилгаан хангамжид	ТНААХ, Цахилгаан дулаан, цэвэр бохир ус	төсвийн хөрөнгө оруулалта					<p>Гэрэл цахилгаангүй болон хүчдэлийн уналттай өрхийг цахилгаан эрчим хүчээр үе шаттай хангана гэж заасаны дагуу Хан-Уул дүүргийн 12 дугаар хороо Туслах аж ахуйн задгай, Сонгино 27-28 дугаар гудамжны айл өрхүүд, 13-р хороо</p>	100

	холбогдоогүй айл өрхийг цахилгаан хангамжид холбож, хүчдлийн уналттай айл өрхийн цахилгаан хангамжийг сайжруулна	хариуцсан мэргэжилтэн Т.Ган-Эрдэнэ						Цагаан эргийн айл өрх, 13-р хороо Сэнс толгойн 8-р хэсгийн цахилгаангүй айл өрхийн цахилгаан хангамж, 13-р хороо Туул тосгоны 4Б-р гудамжны цахилгаангүй айл өрхийн цахилгаан хангамж, 14 дүгээр хороо Бурхантын задгай айл өрхүүд, , 14-р хороо Өлзийтийн дэнжийн 18-р хэсгийн цахилгаангүй айл өрхийн цахилгаан хангамж, 14-р хороо Өлзийтийн дэнжийн 17-р хэсгийн цахилгаангүй айл өрхийн цахилгаан хангамж хүчдэлийн уналтыг бууруулах, Мөн түлхүүр гардуулах гэрээгээр 13-р хороо, 5 дугаар хэсгийн "Шинэ суурьшлын бүс"-ийн цахилгаан хангамж, 13-р хороо, Сэнс толгой 2, 3, 5 дугаар хэсгийн цахилгаан хангамжийн цахилгаан хангамжид холбох ажлыг Улсын төсвийн хөрөнгөөр Эрчим хүчний яаманд гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж гэрээ байгуулан 757 айл өрхийг шинээр цахилгаан эрчим хүчинд холбогдож ашиглалтанд орсон.	
125	Улаанбаатар хотын захирагчийн ажлын албатай хамтран Тулга системд холбогдоогүй 22 ширхэг хуучин гэрэлтүүлгийн удирдлагын самбарыг шинэчлэх ажлыг хийж хэрэгжүүлнэ. Дүүргийн хөрөнгө оруулалтаар 12, 13, 14 дүгээр хорооны гэр хорооллын гудамжнуудад шинээр	ДБТХ, СӨХ, тохижилт, гэрэлтүүлэг хариуцсан мэргэжилтэн	Дүүргийн хөрөнгө оруулалт 300 сая.т					Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар Хан-Уул дүүргийн 13 дугаар хорооны гэр хорооллын гудамжинд шинээр гэрэлтүүлэг хийгдэхээр 187.9 сая.төгрөг батлагдсан. Нийслэлийн худалдан авах ажиллагааны газраас заралсан тендерт "ESP" ХХК шалгарч тус ажлыг 2017 оны 10 дугаар сарын 25-ны өдөр комисс ажиллан 106 гэрэлтүүлэг хүлээн авч бүрэн ашиглалтанд орууллаа.14 дүгээр хорооны Өлзийтийн гэр хорооллын 1 , 5, 6 дугаар гудамжинд нийт 50 гэрэлтүүлэг шинээр хийгдэж ашиглалтанд оруулсан	100

	гэрэлтүүлэг тавих ажлыг хэрэгжүүлнэ								
126	Аялал жуулчлалын авто замын шинэчлэлтийн хүрээнд 2.05км авто зам шинээр байгуулна. /11-р хороо/	ТНААХ,Дэд бүтцийн асуудал хариуцсан мэргэжилтэн Т.Ган-Эрдэнэ	Нийслэлийн хөрөнгө оруулалтаар					Нийслэлийн төсвийн хөрөнгөөр Богдхан уулын дархан цаазат газарт Аялал жуулчлалын зориулалттай, нийт 264 авто машины зогсоол бүхий 2,05 км авто замыг Наранбулаг-Хан” ХХК барьж, ашиглалтад оруулсан.	100
127	Зайсангийн авто замаас Зайсан толгойн урдуур Богд уулын арын авто замтай холбогдох 2.4 км авто замыг шинээр байгуулна.	ТНААХ,Дэд бүтцийн асуудал хариуцсан мэргэжилтэн Т.Ган-Эрдэнэ	Нийслэлийн хөрөнгө оруулалтаар					Тус хэсгийн авто замыг Нийслэлийн авто замын хөгжлийн газрын хөрөнгөөр “Өргөн говь” ХХК гүйцэтгэж 2017 оны 9 дүгээр сард 2,4 км автозамыг ашиглалтад оруулсан.	100
128	Боловсруулсан түлшийг гэр хорооллын айл, өрхүүдэд түлж хэвшүүлэн, цахилгаан халаалт болон сүүлийн үеийн дэвшилтэт технологийг нэвтрүүлэх, утааг саармагжуулах төсөл хэрэгжүүлэх, хангах, хяналт тавьж ажиллана.	ТНААХ , Агаарын чанар хариуцсан мэргэжилтэн Ч.Ишдулам						Түүхий нүүрсний ил задгай худалдааг таслан зогсоох талаар дүүргийн Засаг даргын А/23 дугаар захирамжийн хүрээнд 4,5,6,8,9,10,16 дугаар хороодын нутаг дэвсгэрт 8 цэг тогтоож, хаягжилт хийлгэж байршуулсан. Нийслэлийн хөрөнгөөр цахилгаан халаалтыг тавиулж туршилт хийх өрхийн судалгаанд 30 өрхийн нэрсийн жагсаалтыг Нийслэлийн агаарын бохирдлыг бууруулах газарт хүргүүлсэн.Гэр хорооллын айл өрхүүдэд түүхий нүүрсийг баяжуулсан хэлбэрт оруулах талаар 12.13.14 дүгээр хороодод хэрэгжүүлэх талаар "Ханан хишиг" ХХК-тай хамтран судалгааг хийсэн.	100
129	Туул голын ай сав газрын дагуух ААН,	ТНААХ , Агаарын чанар хариуцсан						Туул голын ай сав газрын дагуух Уурын болон усан халаалтын зуух эзэмшигч аж ахуй нэгж байгууллагуудад Нийслэлийн	100

	байгууллагын зуухнуудад утаа шүүгч, хуурай болон нойтон үнс баригчтай эсэхэд шалгалт хийж утааны хэмжилт хийнэ.	мэргэжилтэн Ч.Ишдулам						Засаг даргын 2016 оны А/805, 2017 оны А/19 дугаар захирамжийн дагуу халаалтын зуухнуудад утаа шүүгч, нойтон болон хуурай үнс баригчтай эсэхэд хяналт шалгалт, хэмжилтийн ажил дүүргийн хэмжээнд 100% хийж гүйцэтгэсэн. Дүүрэгт үйл ажиллагаа эрхэлж байгаа 36 халаалтын зуухнууд бүгд нойтон болон хуурай үнс баригчтай байсан.	
130	Иргэдийн экологийн боловсролыг дээшлүүлэх хүрээнд ЕБС-н сурагчид болон бусад олон нийтийн байгууллагатай хамтран сургалт зохион байгуулах	ТНААХ , Агаарын чанар хариуцсан мэргэжилтэн Ч.Ишдулам	3.5 сая.т					<p>Дүүргийн хэмжээний уурын болон усан халаалтын зуухны механик, галч нарт хөдөлмөр аюулгүй ажиллагаа, уурын зуухны урсгал засвар, их засвар, Агаарын чанарын индексийг зөв танин унших, шинээр мөрдөх 5043:2016 стандарт зэрэг сэдвээр сургалтыг дүүргийн Тамгын газрын хурлын зааланд 2017 оны 5 дугаар сарын 15, 6 дугаар сарын 8-нд тус тус зохион байгуулсан.</p> <p>Сургалтанд нийт 114 хүн оролцсон. Нийслэлийн агаарын бохирдлыг бууруулах газартай хамтран дүүргийн 1,2,3,4,5,6,7,8,9,10,11,15,16-р хороодын 90 хэсгийн ахлагч нарт НИТХ-н 2017 оны 07/01 тоот тушаалаар батлагдсан “Агаарын чанарыг сайжруулах бүсэд хэрэгжүүлэх тусгай төлөвлөгөө”-г танилцуулж түүнийг мөрдөх журам, хэрэгжүүлэх арга зам сүүлийн үеийн дэвшилтэт технологийг хэрэглэх талаар сургалт семинарыг зохион байгуулсан.</p>	100
131	Автозамын хальтиргаа гулгааг арилгахад шаардлагатай элс, давс, бодисны нөөц бүрдүүлж, талбайг тусгай зориулалтын техник хэрэгслээр	ТНААХ, Орчны бохирдол хариуцсан мэргэжилтэн О.Солонгоо	36.0 сая Хэлтсийн төсөв	25	25			<p>Дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа эрхэлж байгаа хороод, СӨХ, Аж ахуйн нэгж, байгууллага, иргэд, ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, төрийн болон төрийн өмчид газруудын ажилтан албан хаагчдыг хамруулан бүх нийтийн их цэвэрлэгээг 22 удаа зохион байгуулж, 1726 аж ахуйн нэгж байгууллага, 55257 иргэнийг хамруулан, гаднах орчны цэвэрлэгээг хийлгэж, хяналт тавьж 548,7 тонн хог хаягдлыг 227 рейсээр төвлөрсөн хогийн цэгт ачиж тээвэрлэх ажлыг хийж гүйцэтгэсэн.</p>	100

	цэвэрлэх ажлыг зохион байгуулж, бүх нийтийн их цэвэрлэгээг 12 удаа зохион байгуулна								
13 АЖЛЫН БИЕЛЭЛТ 100 ХУВЬТАЙ ХЭРЭГЖСЭН									
ЗУРГАА. НИЙГМИЙН ХӨГЖЛИЙН ХЭЛТЭС									
132	Харьяалалгүй ахмад настнуудад хүндэтгэл үзүүлэх	Хөдөлмөр, нийгмийн хамгаалал хариуцсан мэргэжилтэн	76,460.00					“Ахмад настны нийгмийн хамгааллын тухай хууль”-ийн хуульд заасны дагуу тус дүүргийн өрхийн амьжиргааны төвшнөөс доогуур орлоготой өрхийн ахмад настнуудад дүүргийн Засаг дарга хүндэтгэл үзүүлэх үйл ажиллагааг зохион байгууллаа. Хүндэтгэл үзүүлэх үйл ажиллагаанд 16 хорооны нийт 2000 ахмад настан хамрагдсан. Мөн тус дүүргээс төрсөн Хөдөлмөрийн баатар, гавьяат цолтнууд, алдартнуудын төлөөллийг хүлээн авч, хүндэтгэл үзүүлэх үйл ажиллагааг 2017 оны 02 дугаар сарын 16-ны өдөр зохион байгууллаа. Хан-Уул дүүрэгт нийт 250 гаруй Хөдөлмөрийн баатар, гавьяат цолтон, алдартнууд оршин суудагас төлөөлөл болгож 70 ахмадыг хүлээн авч, хүндэтгэл үзүүллээ.	100
133	Нийслэлийн "Цасны баяр"-ын үйл ажиллагаанд зохион байгуулалтыг ханган оролцох	Эрүүл мэнд, биеийн тамир хариуцсан мэргэжилтэн	3,000.00			3,000.00		Монгол Улсын “Биеийн тамир, спортын тухай” хууль, Засгийн газрын 2009 оны 05 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2017 оны 01-р сарын 30-ны А/46 тоот захирамжийн дагуу Нийслэл, дүүргийн нутгийн захиргааны байгууллагуудын ажилтан, албан хаагчдын дунд “Мөнгөн Улаанбаатар” сэдэвт цасны баяр, биеийн тамир, спортын өвлийн үйл ажиллагаа 2017 оны 02 дугаар сарын 04-ний өдөр Хүй долоон худаг дахь “Монгол наадам цогцолбор”-ын UB Resort цанын баазад зохион байгуулагдлаа. Үйл ажиллагаанд тус дүүргийн Засаг даргын Тамгын газрын болон дэргэдэх 21 хэлтэс, алба, хороодын нийт 480 ажилтан, албан хаагчид идэвхтэй оролцож, НЗДТГ, БТСГ-аас оролцогч байгууллагын дунд	100

								зохион байгуулсан “Цасан дээрх бүжгийн тэмцээн”, “Эрүүл хүнсээр аяны хүнс бэлтгэн үдийн цай зохион байгуулах”, “Цасан хотхон байгуулах” “Байгууллага хамт олны дунд спортын уралдаан, тэмцээн зохион байгуулах”, харьяа хэлтэс, алба, хороодын ажилтан, албан хаагчдыг идэвхтэй хамруулсан байдлыг тус тус дүгнэж, байгууллагын нийлбэр дүнгээр тус дүүргийн Засаг даргын Тамгын газар “Дэд” байрт шалгарлаа. Мөн Засаг даргын Тамгын газрын болон дэргэдэх хэлтэс, алба, хороодын ажилтан, албан хаагчдын дунд спортын 3 төрлөөр тэмцээн зохион байгуулж шагнаж урамшууллаа.	
134	"Улаанбаатарын өвлийн наадам-2017" арга хэмжээнд зохион байгуулалтыг ханган оролцох	Эрүүл мэнд, биеийн тамир хариуцсан мэргэжилтэн	1,500.00					Нийслэлийн Засаг даргын тамгын газар, Нийслэлийн аялал жуучлалын газраас зохион байгуулсан “Улаанбаатарын өвлийн наадам гэр бүлийн баяр”-ын арга хэмжээнд нийт 545 гаруй иргэд оролцсон. Тус баяраар хороодын иргэд идэвхтэй хамрагдан цасан урлал болон гэр бүлийн буухай тэмцээнүүдэд идэвхтэй оролцож, Шилдэг эмэгтэй шагналд 2 дугаар хорооны иргэн н.Тогтох, Шилдэг хүүхэд шагналд н.Батнаран нар шалгарлаа.	100
135	Эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийн мэргэжлийн ур чадварыг дүгнэх, чанар үр дүнгийн үзүүлэлтээр урамшуулах ажлыг зохион байгуулах	Эрүүл мэнд, биеийн тамир хариуцсан мэргэжилтэн	1,500.00					Дүүргийн нутаг дэвсгэрт эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлж байгаа шилдэг Өрхийн эрүүл мэндийн төв, шилдэг эмч, шилдэг сувилагч, шилдэг эрүүл мэндийн байгууллагын ажилтан тус тус шалгаруулах үйл ажиллагааг 2017 оны 12 дугаар сарын 28-ны өдөр зохион байгууллаа. Шилдэг ӨЭМТ-өөр Энхбуянтманал, Мэндсаруул, Уясах, Шилдэг менежерээр НЭ-ийн дарга Д.Бааст, Энхбуянтманал ӨЭМТ-ийн дарга М.Алтанхуяг, шилдэг нийгмийн ажилтнаар Мэндсаруул ӨЭМТ-ийн нийгмийн ажилтан Х.Ононтуул, шилдэг сувилагчаар Амгалан-өрх ӨЭМТ-ийн сувилагч Ш.Норовцэрэн, шилдэг эмчээр Н.Отгонсүрэн нар тус тус шалгарсан.	100
136	Халдварт болон халдварт бус өвчин, эх хүүхдийн	Эрүүл мэнд, биеийн тамир хариуцсан	1,500.00					Халдварт өвчин судлалын үндэсний төв ДОХ/БЗДХ-ын тандалт судалгааны албатай хамтран 2017 оны 02 дугаар сарын 15-ны өдөр ХДХВ, бэлгийн замаар дамжих халдварыг	100

	эндэгдэл, гэрийн төрөлтийг бууруулах чиглэлээр сургалт зохион байгуулах	мэргэжилтэн						бууруулах талаар дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа 35 зочид буудал, сауны газрын эзэд болон 86 ажилтнуудад БЗДХ, ХДХВ, ДОХ-ын талаар мэдлэг олгох, бэлгэвчийг тогтмол, хүртээмжтэй байршуулах, түүнд хяналт тавих талаар сургалт явуулсан. Томуу, томуу төст өвчнөөс урьдчилан сэргийлэх, бэлэн байдлын хангах, идэвхжил, дэгдэлтийн үед хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан эмч, ажилчдад зориулсан мэдээлэл сургалт, иргэдэд чиглэсэн сургалт сурталчилгаа, томуугийн эсрэг дархлаажуулалтад хамруулах, эмнэлгийн тусламж үйлчилгээний бэлэн байдлыг хангах, нөөцийг бүрдүүлэх талаар төрийн болон төрийн бус өмчийн сургууль, цэцэрлэгийн эмч нар, өрхийн эрүүл мэндийн төвийн нийт 141 эмч нарт "ХӨЦМ-ийн маягтаар 0-5 хүртэлх насны хүүхдийг үнэлж ангилах", "Өвчтэй хүүхдийн хооллолт", амилуулах болон яаралтай тусламж үзүүлэх, эрэмбэлэн ангилах, сүрьеэгээс сэргийлэх сургалтуудыг нийт 3985 иргэд, сурагчдад томуугаас хэрхэн сэргийлэх, шүүлтүүртэй амны хаалт хэрэглэж хэвших, ханиаж, найтаах соёлын талаар сургалт, видео хичээлүүд зохион байгуулсан. "Томуугаас сэргийлье" гарын авлага 2500 ширхэг хэвлүүлэн Эрүүл мэндийн төв болон ӨЭМТ-үүдээр дамжуулан иргэдэд тараасан. "Чихрийн шижин өвчнөөс урьдчилан сэргийлье", "Хөдөлгөөн ба эрүүл мэнд" зэрэг сэдвүүдээр иргэдэд сургалт явуулсан. Эрүүл мэндийн төвтэй хамтран Ерөнхий боловсролын сургууль болон ӨЭМТ-ийн эмч нарт дархлаажуулалт, "Бэлгийн бойжилт", "Өсвөр насны онцлог", "Охидын бэлгийн ариун цэвэр", "БЗДХӨ түүнээс урьдчилан сэргийлэх" сэдвүүдээр сургалт тус тус зохион байгуулсан.	
137	Дүүргийн Засаг даргын нэрэмжит "Хүүхдийн урлагийн Их наадам" зохион	Боловсрол, ТББ, соёл урлаг хариуцсан мэргэжилтэн	8,000.00					Хүүхдийн авьяас, чадварыг нээн хөгжүүлэх зорилготой "Хүүхдийн урлагийн Их наадам"-ыг жилдээ амжилттай зохион байгууллаа. Наадамд төрийн өмчийн 22 цэцэрлэг, төрийн бус өмчийн 10 цэцэрлэг, төрийн өмчийн 17 сургууль, төрийн бус өмчийн 2 сургуулийн сурагчдын дунд урлагийн 3-6 төрлөөр	100

	байгуулах						зохион байгуулж шилдэг сургууль, цэцэрлэг, багш нарыг шалгарууллаа. Шилдэг цэцэрлэгээр Б.Баярмаа эрхлэгчтэй Нийслэлийн тэргүүний 65-р цэцэрлэг, шилдэг сургуулиар гадаад хэлний гүнзгийрүүлсэн сургалттай Улсын тэргүүний 18 дугаар сургууль тус тус шалгарав. Мөн шилдэг багшаар Нийслэлийн тэргүүний 65-р цэцэрлэгийн хөгжмийн багш АБТ, МУСТА Д.Алтансүвд, гадаад хэлний гүнзгийрүүлсэн сургалттай Улсын тэргүүний 18-р сургуулийн хөгжмийн багш АБТ, МУСТА О.Дорждэрэм, АБТ, МУСТА Ч.Батболд нар шалгарлаа.. СУИС-ын Хөгжмийн урлагийн сургуультай хамтран 18-р сургуулийн 12-р ангийн сурагч Э.Төгөлдөр, 114-р сургуулийн 12-р ангийн сурагч Б.Батжаргалд тус тус СУИС-д элсэн суралцах эрхийн бичиг олгосон.	
138	"Олон Улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдөр"-ийг тэмдэглэн өнгөрүүлэх	Хүүхэд, залуучуудын асуудал хариуцсан мэргэжилтэн	4,500.00				Дүүргийн Засаг даргын 2017 оны А/126 дугаар захирамжаар Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийн арга хэмжээг зохион байгуулах Ажлын хэсгийг батлуулсан. "Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдөр"-ийг дүүргийн нутаг дэвсгэрийн хэмжээнд тэмдэглэн өнгөрүүлэх, соёл урлаг, спортын арга хэмжээг хороо тус бүр өөрийн нутаг дэвсгэрийн онцлог байдлаар 2017 оны 05 дугаар сарын 26-аас 2017 оны 06 дугаар сарын 31-ний өдрүүдэд, дүүргийн нэгдсэн үйл ажиллагаа "Ирээдүйн эзэд" сэдвээр 2017 оны 06 дугаар сарын 1-ний өдөр Төв цэнгэлдэх хүрээлэнд зохион байгуулагдсан. Баярын үйл ажиллагаанд тус дүүргийн 1700 гаруй хүүхэд оролцсон. Дүүргийн бүтэн өнчин, хагас өнчин, хөгжлийн бэрхшээлтэй болон зорилтот бүлгийн 1700 хүүхдэд дүүргийн Засаг даргын гарын бэлгийг хороодын баяр болон нэгдсэн үйл ажиллагааны үеэр гардуулан өгч хүүхдүүдийг урамшууллаа.	100
139	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль тогтоомж, дээд шатны Засаг	Хөдөлмөр, нийгмийн хамгаалал хариуцсан мэргэжилтэн	1,500.00			1,500.00	ХАБЭА-н сарын аяны нээлт ажил олгогчдын зөвлөгөөн хэлэлцүүлэгийг " Ажлын бөйрны эрсдэлийн үнэлгээг сайжруулъя " уриан дор дүүргийн Соёлын ордонд 2017.04.05 – ны өдөр зохион байгуулав.Нээлтийн арга хэмжээнд нутаг дэвсгэрийн 150 гаруй ААНБ, ХАБЭА-н ажилтнууд оролцож,	100

	даргын шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулах						ХАБ-н чиглэлээр мэдээлэл зөвлөгөө авч, харилцан туршлага солилцсон зөвлөгөөн боллоо. Дүүргийн Засаг даргын А/68 дугаар захирамжаар байгуулсан ажлын хэсгийн бүрэлдэхүүн сарын аяны хүрээнд ХАБ-ын чиглэлээр 11 ажил хийхээр төлөвлөн, хэрэгжүүлэх ажлыг хэлтэс, алба, ААНБ-н хүч оролцоотойгоор зохион байгуулсан болно. Үүнд: Аяны ажлын хүрээнд нийслэл, дүүргийн мэргэжлийн байгууллага, хэлтсүүдтэй хамтран төрөл бүрийн сургалтыг 7 удаа, нээлттэй хаалганы өдөрлөг 1 удаа, ЕБС-ийн ахлах ангийн сурагчдын дунд “эрүүл аюулгүй ажлын байр” эссэ бичлэгийн уралдаан 1 удаа, хяналт шалгалт 1 удаа, ажил олгогчийн зөвлөгөөн-2017 шилдэг шимтгэл төлөгч, ажил олгогч байгууллага шалгаруулах арга хэмжээ 1 удаа зэрэг ажлуудыг үе шаттай зохион байгуулан, дээр хийгдсэн ажлуудад давхардсан тоогоор 1730 хүн оролцож, ХАБЭА-н тухай хуульд нийцүүлэн гаргасан дүрэм журмуудын талаар мэдлэг мэдээлэлтэй болж, сургалтанд хамрагдсан ААНБ-дын ХАБЭА-н ажилтнууд ажлын байранд дээрх эрсдэлийг хэрхэн илрүүлэх, үнэлгээ хийх, арилгах талаар зохих мэдлэг чадвартай болсон арга хэмжээ болж өндөрлөлөө.	
140	"Гэртээ харих зам" хөтөлбөрийн хэрэгжилтийг ханган ажиллах	Хөдөлмөр, нийгмийн хамгаалал хариуцсан мэргэжилтэн	3,000.00		100	3,000.00	Орон гэргүй тэнэмэл амьдралтай иргэдийг нийгэмшүүлэх "Гэртээ харих зам" хөтөлбөрийн хэрэгжилтийг ханган ажиллах Ажлын хэсгийг дүүргийн Засаг даргын 2017 оны 02 дугаар сарын 02-ны өдөр А/24 дүгээр захирамжаар байгуулсан. Дараах ажлуудыг хэрэгжүүлсэн. • Дүүргийн нутаг дэвсгэрт амьдарч буй орон гэргүй тэнэмэл амьдралтай иргэдийг бүртгэлжүүлэх, мэдээллийн сантай болох, эрүүл мэндийн үзлэгт хамруулах ажлыг Засаг даргын Тамгын газрын Нийгмийн хөгжлийн хэлтэс, Цагдаагийн 1 болон 2 дугаар хэлтэс, ЭМТ, Улаан загалмай хороо, Эрүүл Мэндийн Төв, Хөдөлмөр, Халамжийн Үйлчилгээний хэлтэс, ГБХЗХХ зэрэг хэлтэс албадтай 2017 оны 06 дугаар сарын 09-ний өдөр зохион байгууллаа. Энэхүү үзлэгт 96 иргэнийг чээжний рентген зураг авах, дотор,	100

								<p>мэдрэл, гэмтэл, ДОХ, тэмбүүгийн түргэвчилсэн шинжилгээнд хамруулсан.</p> <ul style="list-style-type: none"> • 11 дүгээр сарын 14-ний өдөр НХХ, Улаан загалмай хороо, Цагдаагийн 1 болон 2 дугаар хэлтэс, Мария эх сүм ТББ хамтран дүүргийн СӨХ-ны орцны жижүүр, орц, подвальд амьдардаг, орон гэргүй тэнэмэл нийт 110 хүнд Сүрьеэгийн идэвхтэй илрүүлэлт болон нийгмийн дэмжлэг үзүүлж хоол, дулаан хувцсаар ханган эрүүл мэндийн үзлэгт хамруулсан. ГБХЗХХ, Цагдаагийн 1 болон 2 дугаар хэлтэс хамтран Хараа хяналтгүй хүүхдийг илрүүлэх, цахим тоглоомын газруудыг хяналт шалгалтыг 4 удаа хийж, цаг хэтрүүлэн ажиллаж буй 11 цахим тоглоомын газрын үйл ажиллагааг зогсоосон. Мөн бага насны 24 хүүхдийг гэрт нь хүлээлгэн өгч, 4 хүүхдийг СХТ Цогцолборт байршуулан ажилласан. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд зохион байгуулсан хамтарсан үзлэгт хамрагдсан 96 хүнийг оршин суух хаяг, харгалзан дэмжигч нарт нь хүлээлгэн өгөх ажлыг 2, 3, 4, 5, 6, 7, 9, 10, 16 дугаар хорооны хөгжлийн ниймийн ажилтан, хорооны цагдаагийн ажилтнуудын хүч оролцоотойгоор зохион байгууллаа. үзлэгт хамрагдсан иргэдээс тэнэмэл амьдралтай хэдий ч орон гэргүй харгалзан дэмжигчгүй иргэд илрээгүй болно. • 11 дүгээр сарын 15-ны өдөр ЦЕГ-ын даргын тушаалаар Нийслэл болон хөдөө орон нутагт байгаа гэр оронгүй, тэнэмэл иргэд болон хараа хяналтгүй хүүхдүүдийг илрүүлэх, бүртгэл судалгаанд авах, эмнэлгийн үзлэгт хамруулах, эцэг эх, асран хамгаалагчийг олж тогтоох, хүлээлгэж өгөх, нийгэмшүүлэх, нийгмийн хамгааллын төв болон төрийн бус байгууллагын халамжийн төвд хүлээлгэж өгөх, эрх зүйн зөвлөгөө өгөх ажлыг зохион байгууллаа. Энэхүү арга хэмжээнд дүүргийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн хөгжлийн хэлтэс, Хан-Уул дүүргийн цагдаагийн 1 болон 2 дугаар хэлтэс хамтран ажиллаа. Хан-Уул дүүргийн 25 иргэн хамрагдсан. 		
141	Дүүргийн Засаг	Эрүүл мэнд,	50	0	10	0	50	0	Биеийн тамир, спортыг бүх нийтийн хөдөлгөөн болгох	100

	даргын нэрэмжит "Цомын аварга" шалгаруулах тэмцээнийг зохион байгуулах	биеийн тамир хариуцсан мэргэжилтэн						ажилтан албан хаагчдын бие бялдрыг чийрэгжүүлэх зорилгоор Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газар, дэргэдэх хэлтэс албадын ажилтан албан хаагчдын дунд дүүргийн Засаг даргын нэрэмжит спортын 5 төрөлт цомын аварга шалгаруулах тэмцээнийг 2017 оны 09 дүгээр сарын 30-ны өдрөөс 2017 оны 10 дугаар сарын 30-ны өдрүүдэд зохион байгууллаа. Спортын 5 төрөлт /Боулинг, дартс, сагсан бөмбөг, гар бөмбөг, хөл бөмбөг/-өөр нийт 18 хэлтэс, албадын нийт 700 гаруй албан хаагч /давхардсан тоогоор/ хамрагдсан. Байгууллагын нэгдсэн дүнгээр 1-р байрт Татварын хэлтэс, 2-р байрт Цагдаа нэгдүгээр хэлтэс, 3-р байрт Засаг даргын Тамгын газар шалгарлаа.	
142	Хороодын "Хамтарсан баг"-ийн гишүүдийн ур чадварыг дээшлүүлэх зорилгоор шат дараалсан сургалт зохион байгуулах, Шилдэг хамтарсан багийг шалгаруулж урамшуулах	Хүүхэд, залуучуудын асуудал хариуцсан мэргэжилтэн	2,500.00					Хороодын хамтарсан багийн гишүүдийг чадавхжуулах зорилгоор "Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх" тухай хуулийн шинэчилсэн найруулга, хамтарсан багийн тухай ойлголт сургалтыг 16 хорооны Засаг дарга, хөгжлийн нийгмийн ажилтнуудад Хүчирхийлэлийн эсрэг үндсэний төвтэй хамтран 2017 оны 05 дугаар сарын 02-ны өдөр зохион байгуулав. Нийслэлийн хүүхэд, гэр бүлийн хөгжлийн газар, дүүргийн Гэр бүл хүүхэд, залуучуудын хөгжлийн хэлтэс, Дэлхийн Зөн Монгол ОУБ, НҮБ-ын Хүүхдийн сантай хамтран "Хариуцлагатай хамтарсан баг" сургалтыг 2017 оны 05 дугаар сарын 24-ний өдөр дүүргийн Соёлын ордонд зохион байгууллаа. Сургалтад хороодын Засаг дарга, хөгжлийн нийгмийн ажилтан, цагдаагийн ажилтан, халамжийн ажилтан, өрхийн эрүүл мэндийн төвийн ажилтан нийт 65 албан хаагч хамрагдсан. 2017 оны 10 дугаар сарын 20-ны өдөр хороодын хамтарсан багийн кейс менежер "Хөгжлийн нийгмийн ажилтнуудыг чадавхжуулах нь" сургалтыг Шинэ хөгжлийн түлхүүр ТББ, ШУТИС-БуИС, АБНТБТ-тэй хамтран зохион байгуулсан. Хороодын дунд ур чадварын тэмцээн зохион байгуулж, шилдэг кейс менежерээр 7-р хорооны нийгмийн ажилтан Р.Солонго, 2-р байрт 1-р хорооны нийгмийн ажилтан Р.Сарангэрэл, 3-р байрт 5-р хорооны нийгмийн ажилтан	100

								Д.Энхжаргал нар тус тус шалгарлаа.	
143	“Замын хөдөлгөөний цагаан толгой-2017” тэмцээнийг зохион байгуулах	Боловсрол, ТББ, соёл урлаг хариуцсан мэргэжилтэн	2,500.00					Сургуулийн өмнөх насны хүүхдүүдийг зам тээврийн осол хэргээс урьдчилан сэргийлэх, замын хөдөлгөөний дүрмийн мэдлэг олгох, хөдөлгөөнд соёлтой оролцох дадлага эзэмшүүлэх зорилгоор тус дүүргийн цэцэрлэгийн хүүхдүүдийн дунд “Замын хөдөлгөөний цагаан толгой-2017” тэмцээнийг 2017 оны 05 дугаар сарын 02-ны өдөр зохион байгууллаа. Тэмцээнд дүүргийн төрийн өмчийн 20, төрийн бус өмчийн 1 цэцэрлэгийн нийт 21 баг оролцсон бөгөөд урьдчилан өгсөн удирдамжийн дагуу гэрийн даалгавар, мэндчилгээ, хамтдаа, багийн ахлагчийн тэмцээн, урлагийн тоглолтуудыг бэлтгэн 5 төрөлд өрсөлдөж, тэмцээний дүнгээр 71 дүгээр цэцэрлэг 1-р байранд шалгарч Цом, өргөмжлөл, алтан медаль, мөнгөн шагналаар, 67 дугаар цэцэрлэг 2-р байранд шалгарч өргөмжлөл, мөнгөн медаль, мөнгөн шагналаар, 219 дүгээр цэцэрлэг 3-р байранд шалгарч өргөмжлөл, хүрэл медаль, мөнгөн шагналаар тус тус шагнагдлаа.	100
144	"Олон Улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдөр"-ийг тэмдэглэн өнгөрүүлэх	Хүүхэд, залуучуудын асуудал хариуцсан мэргэжилтэн	8,000.00					Дүүргийн Засаг даргын 2017 оны А/126 дугаар захирамжаар Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийн арга хэмжээг зохион байгуулах Ажлын хэсгийг батлуулсан. "Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдөр"-ийг дүүргийн нутаг дэвсгэрийн хэмжээнд тэмдэглэн өнгөрүүлэх, соёл урлаг, спортын арга хэмжээг хороо тус бүр өөрийн нутаг дэвсгэрийн онцлог байдлаар 2017 оны 05 дугаар сарын 26-аас 2017 оны 06 дугаар сарын 31-ний өдрүүдэд, дүүргийн нэгдсэн үйл ажиллагаа "Ирээдүйн эзэд" сэдвээр 2017 оны 06 дугаар сарын 1-ний өдөр Төв цэнгэлдэх хүрээлэнд зохион байгуулагдсан. Баярын үйл ажиллагаанд тус дүүргийн 1700 гаруй хүүхэд оролцсон. Дүүргийн бүтэн өнчин, хагас өнчин, хөгжлийн бэрхшээлтэй болон зорилтот бүлгийн 1700 хүүхдэд дүүргийн Засаг даргын гарын бэлгийг хороодын баяр болон нэгдсэн үйл ажиллагааны үеэр гардуулан өгч хүүхдүүдийг урамшууллаа.	100

145	"Дээлтэй Монгол-2017" арга хэмжээнд зохион байгуулалтыг ханган оролцох	Боловсрол, соёл хариуцсан мэргэжилтэн ТББ, урлаг	1,500.00					Тулгар төр байгуулагдсаны 2226 жил, Их Монгол улс байгуулагдсаны 811 жил, Ардын хувьсгалын 96 жилийн ойн үндэсний их баяр наадмаар Монголчуудын уламжлалт өв соёлыг дэлхийд сурталчлан таниулах, түгээн дэлгэрүүлэх, аялал жуулчлалыг хөгжүүлэх үндэсний бахархлыг төрүүлэх зорилгоор зохион байгуулагдсан "Дээлтэй монгол-2017" наадам нь 2017 оны 07 дугаар сарын 10-ны өдөр зохион байгуулагдсан 6 Уг арга хэмжээнд Хан-Уул дүүргийн төр захиргааны байгууллагын албан хаагчид, 16 хорооны иргэд, албан хаагчид нийт 900 гаруй хүний бүрэлдэхүүнтэйгээр оролцож "Дээлтэй монгол" наадмын шилдэг дүүргийн 3 дугаар байранд шалгарлаа. Хан-Уул дүүрэг өөрийн хүрээнд амжилттай оролцсон хэлтэс алба, хороог шалгаруулан "Өргөмжлөл", мөнгөн шагналаар шагналаа. Шилдэг зохион байгуулалттай оролцсон байгууллагаар: Ахмадын хороо Шилдэг зохион байгуулалттай оролцсон хороогоор: 1-р байр 7-р хороо 2-р байр 6-р хороо 3-р байр 14-р хороо тус тус тодорлоо.	100
146	"Ногоон гэрэл, цагаан шугам-2017" тэмцээнийг зохион байгуулах	Боловсрол, соёл хариуцсан мэргэжилтэн ТББ, урлаг	2,500.00					Жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг "Ногоон гэрэл-Цагаан шугам 2017" тэмцээнийг дүүргийн хэмжээнд 2017 оны 10 дугаар сарын 23-ны өдөр төрийн өмчийн 17-н сургуулиудын амжилттай зохион байгууллаа. Төрийн өмчийн 17-н сургуулиас 18-р сургуулийн баг тэргүүн байр эзэлж "Цом, Өргөмжлөл, Алтан медаль"-аар, 15-р сургуулийн баг дэд байр эзэлж "Өргөмжлөл, Мөнгөн медаль"-аар, 34-р сургуулийн баг 3-р байр эзэлж "Өргөмжлөл, хүрэл медаль"-аар, 52-р дунд сургууль тусгай байранд шалгарч "Өргөмжлөл"-өөр тус тус шагнагдлаа.	100
147	Нийслэлийн Засаг даргын нэрэмжит "Их нүүдэл"	Боловсрол, соёл хариуцсан ТББ, урлаг	1,500.00					Нийслэлийн 378 жилийн ойн хүрээнд Дүүргийн Засаг даргын Тамгын газраас Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдыг шатрын спортоор хичээллүүлэн оюуны чадамжийг	100

	шатрын тэмцээн зохион байгуулах	мэргэжилтэн						дээшлүүлэх тоглох ур чадварыг нээн илрүүлэх, ирээдүйн их мастеруудыг төрүүлэн гаргах, шатрын спортыг хөгжүүлэх зорилгоор жил бүр уламжлал болгон зохион байгуулагддаг "Их нүүдэл" шатрын тэмцээнийг 2017 оны 10 дугаар сарын 14-ний өдөр 41 дүгээр сургууль дээр зохион байгууллаа. Тэмцээнд төрийн өмчийн Буянт-Ухаа, 10, 15, 18, 26, 32, 34, 41, 52, 59, 60, 75, 114, 115, 118 дугаар сургуулиуд, төрийн бус өмчийн Этүгэн сургуулийн нийт 16 сургуулийн 386 сурагч оюун ухаанаа сорин өрсөлдсөн. 1-р байрт Б.Цэцэгмаа багштай 52 дугаар сургууль Цом, өргөмжлөл, мөнгөн шагнал, 2-р байрт С.Эрдэнэсүх багштай 115 дугаар сургууль, 3-р байрт Х.Ганболд багштай 60 дугаар сургууль тус тус шалгарч өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнагдлаа. Шалгарсан хүүхэд багачуудад медаль, гарын бэлэг гардууллаа.	
148	Д.Лувсаншаравын нэрэмжит "Хүүхдийн найрал дууны шилдэг хамтлаг шалгаруулах" уралдаант наадмыг зохион байгуулах	Боловсрол, ТББ, соёл урлаг хариуцсан мэргэжилтэн	2,500.00					Нийслэлийн Ерөнхий боловсролын сургуулиудын хөгжмийн хичээлийн сургалтыг чанаржуулж, өсвөр үеийнхэнд уран сайхны боловсрол олгох, гоо зүйн хүмүүжлийг төлөвшүүлэх, хүүхэд бүрийн авьяасыг хөгжүүлэх зорилгоор Нийслэлийн Засаг даргын ивээл дор жил бүр уламжлал болон зохиогддог Монгол улсын Хөдөлмөрийн баатар, Төрийн шагналт, Ардын жүжигчин Дагвын Лувсаншарав агсны нэрэмжит "Хүүхдийн найрал дууны шилдэг хамтлаг" шалгаруулах уралдаан 10 дугаар сарын 12-ны өдөр Хан-Уул дүүргийн Соёлын ордонд зохион байгуулагдлаа. Тус тэмцээний 1 дүгээр шатны шалгаруулалтад Хан-Уул дүүргийн Ерөнхий боловсролын 15 сургууль оролцож шилдгүүдээ шалгарууллаа. Нийслэлийн шалгаруулалтад 52 дугаар сургууль Тусгай байр, 18 дугаар сургууль Д. Лувсаншаравын нэрэмжит шагналыг тус тус эзэллээ. Амжилттай оролцсон 2 сургууль 2017 оны 10 дугаар сарын 28-ны өдөр Соёлын төв өргөөнд зохион байгуулагдсан "Найрал дууны хамтлагуудын нэгдсэн тоглолт"-д оролцов.	100

149	Олон Улсын ахмадын баярыг угтан хүндэтгэл үзүүлэх арга хэмжээг зохион байгуулах	Хөдөлмөр, нийгмийн хамгаалал хариуцсан мэргэжилтэн	8,000.00					Олон Улсын ахмадын баярыг угтан хүндэтгэл үзүүлэх арга хэмжээг “Ахмадаа дээдэлье” уриатайгаар хороо тус бүр өөр өөрийн онцлогтойгоор зохион байгуулсан бөгөөд ахмадуудын гар урлалын бүтээлийн үзэсгэлэн, спорт урлагийн олон төрлийн тэмцээн уралдааныг зохион байгуулсан. Нийт арга хэмжээнд 8000 гаруй ахмад настан хамрагдсан.	100
150	Монголын болон Олон Улсын багш нарын баярыг угтан дүүргийн тэргүүний сургууль, цэцэрлэгийг шалгаруулж, урамшуулах	Боловсрол, ТББ, соёл урлаг хариуцсан мэргэжилтэн	3,000.00					Дүүргийн ЗДТГ-аас зохион байгуулсан “Оны тэргүүний сургууль, цэцэрлэг, шилдэг удирдлагууд, ажилтан албан хаагч”-ыг тодруулж, шагнаж урамшуулах ажлыг зохион байгуулах ажлыг 2017 оны 12 дугаар сарын 21-ний өдөр зохион байгууллаа. Шилдэг тогоочоор 73-р цэцэрлэгийн тогооч Б.Маржаачум, Шилдэг эмчээр 28-р цэцэрлэгийн эмч Г.Нямгэрэл, 130-р сургуулийн эмч Д.Оюун, Шилдэг үйлчилгээний ажилтнаар 4-р клиник сувиллын асрагч О.Алтанчимэг, 12-р цэцэрлэгийн жижүүр А.Пүрэвсүрэн, 26-р сургуулийн жолооч Ж.Лхагва, Шилдэг багшаар 115-р сургуулийн химийн багш Т.Батцэцэг, 75-р сургуулийн технологийн багш М.Наранцэцэг, 52-р сургуулийн бага ангийн багш П.Бямбацэрэн, 53-р цэцэрлэгийн бүлгийн багш Ц.Ганчимэг, Шилдэг нийгмийн ажилтнаар 10-р сургуулийн нийгмийн ажилтан Ц.Ундрах, Шилдэг арга зүйчээр 49-р цэцэрлэгийн арга зүйч С.Батцэцэг, Шилдэг сургалтын менежерэр 15-р сургуулийн сургалтын менежер П.Мягмарчулуун, Шилдэг эрхлэгчээр 65-р цэцэрлэгийн эрхлэгч Б.Баярмаа, Шилдэг захирлаар 32-р сургуулийн захирал Г.Мөнхбаяр, Дүүргийн тэргүүний цэцэрлэгээр “Эко гэр”, “Талст-21”, Т.Бямбахорлоо эрхлэгчтэй 35-р цэцэрлэг, Дүүргийн тэргүүний сургуулиар Д.Баянмөнх захиралтай “Шинэ өнөөдөр” сургууль, Р.Өлзийхишиг захиралтай 34-р сургууль тус тус шалгарлаа.	100
151	Богд Хан уулын хишиг бөхийн барилдаан	Эрүүл мэнд, биеийн тамир хариуцсан	3,000.00					Богд Хан уулын хишиг бөхийн барилдааныг 2017 оны 12 дугаар сарын 17-ны өдөр Монгол бөхийн холбоо, Байгаль орчны яамтай хамтран Монгол бөхийн өргөөнд зохион	100

		мэргэжилтэн					байгууллаа. Нийт улс, аймгийн цолтой 128 бөх зодоглосон. Үзэгчдээс хагас саятан хоёрыг, мөн азтан үзэгч хоёрыг тус тус тодрууллаа.	
152	Хан-Уул дүүргийн Биеийн тамир, спорт хамтлагийн үйл ажиллагааг идэвхжүүлэх, дэмжлэг үзүүлэх	Эрүүл мэнд, биеийн тамир хариуцсан мэргэжилтэн	5,000.00				Хан-Уул дүүргийн болон Засаг даргын Тамгын газрын Биеийн тамир, спорт хамтлагийг шинээр байгуулан Засаг даргын Тамгын газрын болон дэргэдэх хэлтэс албадын албан хаагчдын дунд спортын уралдаан тэмцээнийг зохион байгуулан ажиллаж байна. Биеийн тамир, спорт хамтлагтай хамтран дараах арга хэмжээг зохион байгууллаа.Үүнд: Ажилчдын цасны баяр, нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын дунд зохион байгуулагдсан спортын тэмцээн,, “Улаанбаатар марафон-2017” олон улсын гүйлтийн тэмцээнүүдийг амжилттай зохион байгуулж 4152 иргэд, ажилтан, албан хаагчид хамрагдсан.	100
153	Иргэдийн спортын VI Их наадмыг зохион байгуулах	Эрүүл мэнд, биеийн тамир хариуцсан мэргэжилтэн	42,000.00				Хан-Уул дүүргийн Засаг даргын нэрэмжит Иргэдийн спортын VI их наадмыг 2017 оны 05 сараас 10 дугаар сар хүртэл 5 сарын хугацаанд хэсэг, хороо, дүүрэг гэсэн үе шаттайгаар спортын 8 төрлөөр зохион байгуулж, дүүргийн 16 хорооны 5000 гаруй иргэд хамрагдсан. Хан-Уул дүүргийн Иргэдийн спортын VI их наадмыг байгууллагын нэгдсэн дүнгээр: 1-р байрт Ё.Цацралтуяа даргатай 8-р хорооны баг тамирчид, 2-р байрт Ц.Алтангэрэл даргатай 16-р хорооны баг тамирчид, 3-р байрт М.Насанжаргал даргатай 9-р хорооны баг тамирчид тус тус шалгарч цом, өргөмжлөл мөнгөн шагналаар шагнуулсан. Нийслэлийн аварга шалгаруулах тэмцээнд сагсан бөмбөгийн төрөлд 2 дугаар хорооны эмэгтэй баг тамирчид 1-р байр, олс таталтын тэмцээнд 16 дугаар хорооны эмэгтэй баг тамирчид 2-байр, 9 дүгээр хорооны эрэгтэй баг тамирчид 3-р байр, софт волейболын төрөлд 8 дугаар хорооны баг тамирчид 3-р байрт тус тус шалгарсан.	100
154	Дүүргийн "Хөгжлийн бэрхшээлтэй	Хөдөлмөр, нийгмийн хамгаалал	3,000.00			3,000.00	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах ОУ-ийн өдрийг угтан Засаг даргын тамгын газар дүүргийн ХБИ-ийн холбоотой хамтран Дэлхийн ХБИ-ийн холбооноос/ DPI /-с	100

	иргэний зөвлөл"-ийн үйл ажиллагааг идэвхжүүлэх, ХБИ-дийн эрхийг хамгаалах ОУ-ын өдрийг угтан зөвлөгөөн зохион байгуулах	хариуцсан мэргэжилтэн						гаргасан "Нэг ч хүнийг ардаа үлдээхгүй" уриалгыг дэмжин Хүннү молл энтертаймент төвд өдөрлөг зохион байгуулсан. Өдөрлөгт хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн санал санаачилгыг дэмжих замаар нийгмийн амьдралд оролцох оролцоог нэмэгдүүлэх, тэдэнд чиглэсэн төрийн үйлчилгээг сурталчлах, тайлагнах, мэдээллээр хангах зорилгоор 2017 оны 12 дугаар сарын 01-ны өдөр "Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн өдөрлөг"-ийг зохион байгууллаа. Зөвлөгөөнд тус дүүргийн 16 хорооны хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн төлөөлөл 200 гаруй иргэн оролцож, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд тулгамдаж буй асуудал, цаашид шийдвэрлэх шаардлагатай ажлуудын талаар санал бодлоо солилцсон. Өдөрлөгт ХБИ-ийн гар урлалын үзэсгэлэн худалдаа болон урлаг уран сайхны үйлчилгээг үзүүлсэн.	
155	"Зорилтот өрхийн хөгжил, хамгааллыг сайжруулах үндэсний хөтөлбөр"- т хамрагдсан айл өрх рүү чиглэсэн үйл ажиллагааг санаачлан хэрэгжүүлэх	Хөдөлмөр, нийгмийн хамгаалал хариуцсан мэргэжилтэн	1,500.00					"Хан-Уул дүүргийн хэмжээнд ЗӨХХСҮХ-т өрхийн мэдээллийн нэгдсэн санд бүртгэлтэй 2-8 дугаар түвшний 870 өрхийн 5366 иргэнийг хамруулж, өрхийн хөгжлийн гурвалжны дагуу хөгжлийн 3 түвшин, 7 бүлэг, 14 асуудлын 38 үзүүлэлтийн дагуу суурь үнэлгээ хийж, хөгжлийн бүлгийг тодорхойлж, өрхийн хөгжлийн төлөвлөгөөг өрхийн гишүүдтэй хамтран гаргасан. Бага орлоготой иргэдийг ажлын байраар хангах, нийтийг хамарсан ажил арга хэмжээний хүрээнд ""Эко ногоон бүлэг"-ийн 38, ажилгүй зорилтот бүлгийн 640 иргэнийг яармаг, нисэхийн зочдын зам, их тэнгэр,зайсан, Туулын голын сав газар, дунд гол, Богд уулын арын зам, хороолол дундах салбар зам, зэрэг нийтийн эзэмшлийн гудамж талбайг тохижуулах, хог хаягдалгүй байлгах, мод, бут сөөг, цэцэг тарих, далан шуудуу цэвэрлэн, усны болзошгүй аюулаас сэргийлэх, орон нутгийн хөрөнгөөр байгуулагдсан цэцэрлэгт хүрээлэнг харж хамгаалах, цас мөс цэвэрлэн иргэдийн аюулгүй зорчих орчинг бүрдүүлэх зэрэг ажлуудыг үе шаттай зохион байгуулан, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас 184 сая төгрөг зарцуулж, дээрх ажлын үр дүнд 640 иргэн түүний	100

							ард байгаа 640 өрхийн орлого зохих хэмжээгээр нэмэгдсэн.	
156	Иргэдийн шинэ жилийн баяр /Оны шилдгүүдийг шалгаруулах /сурагч, ахмад, залуучууд, эмэгтэйчүүд../	Боловсрол, ТББ, соёл урлаг хариуцсан мэргэжилтэн	3,000.00				"Эко дүүрэг-цасан угалз" харшийн сүлд модны наадмыг 2017 оны 12 сарын 23,24-ний өдрүүдэд нийт 8 удаагийн тоглолт зохион байгуулсан. Тус арга хэмжээнд улаан театр, цасан хатан зохиолоос сэдвэлсэн мюзикл, яг түүн шиг шоуны оролцогчид урлагийн тоглолт үзүүлж, шинэ жилийн баяраар өвлийн өвгөн цасан охидтой хамт сонирхолтой үзвэр үзэж хүүхэд бүрийн хүсэн хүлээдэг мөчийг бэлэглэсэн билээ. Тоглолтод дүүргийн ерөнхий боловсролын бүх сургуулиудын хүүхдүүд хамрагдсан бөгөөд хөгжлийн бэрхшээлтэй, амьжиргааны түвшинээс доогуур орлоготой гэр бүлийн, хагас, бүтэн өнчин, нийгмийн зорилтот бүлгийн нийт 1600 хүүхдүүд хамрагдсан бөгөөд хүүхэд бүрт дүүргийн Засаг даргын гарын бэлэг гардуулсан томоохон үйл ажиллагаа болж өндөрлөлөө. Мөн монголын хараагүйчүүдийн үндэсний холбооны ирүүлсэн албан бичгийн дагуу 30 хүүхдийг сүлд модны наадамд тоглолт үзүүлэн бэлэг гардуулсан.	100
157	Дүүргийн Өсвөрийн шигшээ багийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх	Эрүүл мэнд, биеийн тамир хариуцсан мэргэжилтэн	45,000.00		6,000.00	10,000.00	Монгол Улсын Биеийн тамир, спортын тухай хуулийн 18.8, Нийслэлийн Засаг даргын 2007 оны 621 дүгээр захирамж, дүүргийн Засаг даргын 2015 оны А/07 дугаар захирамж, дүүргийн Засаг даргын 2017-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд Засаг даргын дэргэдэх өсвөрийн шигшээ багийг спортын 10 төрлөөр байгуулан, ажиллаж байна. Үүнд: 1. Сагсан бөмбөгийн дасгалжуулагчаар Спортын мастер М.Гантөмөр 2. Волейболын дасгалжуулагчаар Спортын мастер Ж.Пүрэвжав 3. Жүдо бөхийн дасгалжуулагчаар Монгол Улсын Гавьяат дасгалжуулагч Ш.Цэвэлмаа 4. Тэшүүрийн дасгалжуулагч Олон улсын хэмжээний мастер Л.Алтанцэцэг 5. Хөл бөмбөгийн дасгалжуулагчаар Спортын мастер Б.Болд	100

							<p>6. Ширээний теннисний дасгалжуулагчаар Спортын мастер Д.Мөнхсайхан</p> <p>7. Чөлөөт бөхийн дасгалжуулагчаар А.Энхтөр</p> <p>8. Дугуйн дасгалжуулагчаар Спортын мастер Н.Нармандах</p> <p>9. Софт теннисний дасгалжуулагчаар С. Хулан</p> <p>10. Боксын дасгалжуулагчаар С. Хосбаяр нар ажиллаж, 2017 оны байдлаар өсвөрийн шигшээ багийн 238 тамирчид улс, нийслэл, нэрэмжит 30 төрлийн тэмцээнээс:</p> <p>- Алтан медаль -72</p> <p>- мөнгөн медаль -90</p> <p>-Хүрэл медаль-106 нийт 268 багц медалийг хүртээд байна. Үүнээс: ОУАШТ-ээс алт-9, мөнгө-9, хүрэл-14, УАШТ-ээс алт-21, мөнгө-31, хүрэл-31, ХАШТ-ээс алт-15, мөнгө-11, хүрэл-11, нэрэмжит тэмцээнээс алт-27, мөнгө-36, хүрэл-46 ширхэг медалиудыг хүртсэн амжилттай байна.</p>	
158	Жендэрт суурилсан хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хүчирхийллийг бууруулах чиглэлээр сургалт зохион байгуулах	Хүүхэд, залуучуудын асуудал хариуцсан мэргэжилтэн	1,000.00				<p>Цагдаагийн 1 дүгээр хэлтэс, Цагдаагийн 2 дугаар хэлтэс, Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн хэлтэс, Албан бус насан туршийн боловсролын төвтэй хамтран "Хүн худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх нь", "Жендэрт суурилсан хүчирхийллээс урьдчилан сэргийлэх нь" сургалтуудыг дүүргийн 16 хороодын иргэд, хороодын албан хаагчид, тухайн нутаг дэвсгэрт байрлах ЕБС-ийн сурагчид, Онцгой байдлын 65 дугаар анги, Хангай дээд сургууль, Ардчилсан Залуучуудын холбоо, Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төв, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх 411-р анги, Тохижилт үйлчилгээний хэлтэс, Залуучуудын хөгжлийн төв, Дельта төв, Түр хамгаалах байр зэрэг байгууллагуудад зохион байгуулсан. Сургалтын үр дүнг тооцох зорилгоор сургалт бүрийн сүүлийн 10 минутанд хэлэлцүүлэг зохион байгуулан санал бодлыг сонсон нэгтгэж дүгнэж ажилласан. Цагдаагийн 2 дугаар хэлтсээс "Мишээл экспо" худалдааны төв дээр Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийг сурталчлах чиглэлээр Нээлттэй хаалганы өдөрлөгийг зохион байгуулж иргэдэд хуулийн шинэчлэл өөрчлөлтийг тусгасан</p>	100

								гарын авлагыг зөвлөмжийг тараасан. TV-5, ROYAL, MONGOL HD телевизүүдэд гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, гэр бүлийн хүчирхийллийн талаар хэрхэн мэдээлэх тухай яриа таниулга өгч ажилласан. Жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх 16 хоногийн аяны хүрээнд ХУД-ийн ГБХЗХХ, АБНТБТ-тэй хамтран ерөнхий боловсролын 10, 26, 59 дүгээр сургуулиудын 9-12 дугаар ангийн 164 сурагчдад “Жендэр” гэх нэр томёоны талаар болон жендэрийн тэгш байдлын тухай зөв ойлголт өгөх болон эрэгтэй эмэгтэй хүмүүст багаас нь ялгавартай ханддаг нийгэмд тогтсон хэвшмэл ойлголтыг өөрчлөх зорилгоор сургалтыг, АПУ ХК, Атар өргөө ХК, Витавит ХХК-ний ажилчдад жендэрийн талаарх ойлголт, жендэрт суурилсан хүчирхийллийн талаарх сургалтыг тус тус зохион байгууллаа. Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газар болон дэргэдэх хэлтэс албад 2017 оны 12 дугаар сарын 07-ны өдөр “Цагаан тууз” зүүж энэхүү аяныг дэмжин оролцож “Хүчирхийлэлд үгүй” гэж хэллээ.	
27 АЖЛЫН БИЕЛЭЛТ 100 ХУВЬАЙ ХЭРЭГЖСЭН									
ДОЛОО. ЦЭРГИЙН ШТАБ									
159	Дүүргийн дайчилгаа удирдах бүлэг, батлан хамгаалах товчоо, Цэргийн штабын офицеруудтай хээрийн нөхцөлд штабын дадлага сургалтыг зохион байгуулах	Цэргийн штабын дарга, хурандаа А.Баттулга Н.Насанбат	5,420,000					Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газрын даргын 2017 оны А/167 дугаар тушаалаар Дайчилгаа удирдах бүлгийн сургалтыг 2017 оны 11 дүгээр сарын 14-17-ны өдрүүдэд зохион байгуулсан.	100
160	Нийслэл, дүүргийн ЗДТГ-ын Цэргийн штабын	Цэргийн штабын дарга, хурандаа А.Баттулга	2,320,000					2017 оны 05 дугаар сарын 16, 11 дүгээр сарын 15-ны өдрүүдэд Батлан хамгаалах яамны хурлын танхимд нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабаас	100

	офицеруудын сургалтыг зохион байгуулах	Н.Насанбат						зохион байгуулсан цэргийн штабын офицеруудын сургалтад 100 хувийн ирцтэй хамрагдсан. Сургалтын төлөвлөгөөний дагуу шинэчлэн батлагдсан Батлан хамгаалах бодлогын үндэс баримт бичиг болон багц хуулиар офицер, ахлагч нарын хууль эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх сургалт, харилцан мэтгэлцээнийг 2017 оны 04 дүгээр сарын 26-ны өдөр явуулсан. Мөн сар тутам хуулийн мэдлэгийн түвшинг тогтоох тестийн шалгалтыг авч, тестийн хариултад дүгнэлт хийн харилцан ярилцах ажлыг хэвшүүлсэн.	
161	Хороодын Засаг дарга нарын 2017 оны Цэргийн бэлтгэл сургалтыг зохион байгуулах	Цэргийн штаб	4,076,000					Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын сургалт бэлтгэлийн нэгдсэн төлөвлөгөөний дагуу сургалтыг орон нутгийн зарчмаар Дайчилгааны тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалт, нийслэлийн Засаг даргын 2017 оны А/49 дүгээр захирамж, Батлан хамгаалахын сайд, нийслэлийн Засаг дарга нарын 2017 онд хамтран ажиллах гэрээг тус тус үндэслэн хорооны Засаг дарга нарын цэргийн бэлтгэл сургалтыг 2017 оны 03 дугаар сарын 30-31-ний өдрүүдэд Зэвсэгт хүчний 120 дугаар ангийн цэргийн зэвсэг техник, сургалтын материаллаг баазыг түшиглэн сургалтын хөтөлбөрийн дагуу зохион байгуулсан.	100
162	Орон нутгийн цэргийн отрядын удирдах бүрэлдэхүүний сургалт, штабын дадлага, сургалтыг зохион байгуулна.	Цэргийн штабын дарга, хурандаа А.Баттулга, Н.Насанбат, Г.Жаргалсайхан	100					2017 оны нэгдсэн төлөвлөгөөний дагуу Орон нутгийн цэргийн отрядын удирдах бүрэлдэхүүнтэй 2017 оны 11 дүгээр сарын 27-ны өдөр сургалт зохион байгуулан явуулсан.	100
163	Дайчилгааны бэлтгэл нөөцийн бүрэлдэхүүнийг шинээр болон давтан сургах ажлыг зохион байгуулна.	Цэргийн штабын дарга, хурандаа А.Баттулга, Н.Насанбат, Г.Жаргалсайхан	7,496,000					Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын 2017 оны сургалт, бэлтгэлийн үндсэн арга хэмжээний төлөвлөгөөний дагуу "Телефончин" мэргэжлээр дайчилгааны бэлтгэл нөөцийн бага мэргэжилтэн бэлтгэх сургалтыг Зэвсэгт хүчний 013 дугаар ангийн сургалтын материаллаг баазыг түшиглэн 2017 оны 04 дүгээр сарын 05-14-ний өдрүүдэд зохион байгуулсан.	100

164	2017 оны 1,2 дугаар ээлжийн цэрэг татлага, халалтын ажлыг зохион байгуулна.	Цэргийн штаб	28,128,700					2017 оны цэрэг татлагыг нийслэлийн Засаг даргын 2017 оны А/186, Хан-Уул дүүргийн Засаг даргын 2017 оны А/103 дугаар захирамжаар 2017 оны 05 дугаар сарын 05-07-ны өдрийг дуустал , 2 дугаар ээлжийн цэрэг татлагыг нийслэлийн Засаг даргын 2017 оны А/679, Хан-Уул дүүргийн Засаг даргын 2017 оны А/305 дугаар захирамжаар 2017 оны 10 дугаар сарын 20-22-ны өдрийг дуустал хугацаанд дүүргийн ерөнхий боловсролын 34 дүгээр сургуулийн байранд зохион байгуулсан. Хуурай замын болон Хилийн цэрэгт цэргийн жинхэнэ алба хаалгахаар нийслэлийн Цэрэг татлагын товчооноос өгсөн тоон даалгавраар Зэвсэгт хүчин бусад цэргийг нөхөн хангах цэрэг татлагын тоон даалгаврыг 100 хувь биелүүлсэн.	100
165	Цэрэг татлагын байрны хяналтын камер, гэрэлтүүлэгийн ашиглалтын урсгал засвар, цэрэг татлагын байрны эрүүл мэндийн үзлэг явуулах өрөө, тасалгааг засварлана.	Цэргийн штаб С. Баярмагнай, Н.Насанбат	6,820,000					2017 оны цэрэг татлагаар шинэчлэн батлагдсан Батлан хамгаалах багц хуулиар болон батлан хамгаалах бодлого, Зэвсэгт хүчний үйл ажиллагаа, Оюутан-цэрэг сургалт болон цэргийн алба хаах хэлбэрүүдийг сурталчилсан 5000ш тараах материал, 150ш плакат, 100ш цэргийн бүртгэлийн заавар, 10ш хулдаасан хэвлэл, 3ш хөлтэй анонс шинэчлэн гаргаж, цэргийн алба хаах хэлбэрүүдийн талаар ухуулга сурталчилгааг мэргэжлийн байгууллагуудтай хамтран зохион байгуулсан. Цэрэг татлагын байрны хяналтын 2ш камер шинэчлэн сольж, бүх гэрэлтүүлгийг шалгаж , цэрэг татлагын байрны эрүүл мэндийн үзлэг явуулах өрөө, тасалгааны урсгал засвар хийсэн.	100
166	"Оюутан -цэрэг" хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.	Цэргийн штаб	1,242,000					Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 32 дугаар тогтоол, нийслэлийн Засаг даргын 2017 оны А/100 дугаар захирамж, Монгол Улсын Батлан хамгаалахын сайдын 2016 оны А/379 дүгээр тушаалын дагуу "Оюутан-Цэрэг" сургалтад хамрагдах оюутны бүртгэлийг 2017 оны 03 дугаар сарын 02-09-ний өдрүүдэд дүүргийн Соёлын ордонд зохион байгуулан явуулсан. Их, дээд сургуулиас ирүүлсэн нэрсийн жагсаалтын дагуу бүртгэлийг бүрэн явуулсан. БХИС дээр 2017 оны 03 дугаар сарын 11-ний өдөр эрүүл мэндийн үзлэгт, 2017 оны 03	100

								дугаар сарын 22-ны өдөр биеийн тамирын шалгалтад оюутнуудыг хамруулсан. Хан-Уул дүүргийн 11 их, дээд сургуулийн 118 оюутан бүртгэлд хамрагдсанаас “Оюутан-цэрэг” цэргийн мэргэжил олгох сургалтад 7 их, дээд сургуулийн 86 оюутан цэргийн жинхэнэ албыг хаасан.	
167	Зэвсэгт хүчин байгуулагдсаны 96 жил, Монгол цэргийн өдрийг тохиолдуулан "Монгол цэргийн бахархалын өдөр" -ийг Зэвсэгт хүчний цэргийн анги байгуулагатай, хороо, ЗДТГ-тай хамтран зохион байгуулна.	Цэргийн штаб	6,400,000					Монгол цэргийн өдөр, Зэвсэгт хүчин үүсэн байгуулагдсаны 96 жилийн ойг тохиолдуулан 2017 оны 03 дугаар сарын 14-ний өдөр дүүргийн Засаг даргын Тамгын газар, хороо, Зэвсэгт хүчний 011, 303, 120, 326 дугаар ангиудтай хамтран “Монгол цэргийн бахархал” өдөрлөгийг зохион байгуулсан. Дүүргийн 350 гаруй иргэн хамрагдсан. Дүүргийн ЕБС-ийн ахлах ангийн сурагчдын дунд “Эх орон-Эр цэрэг” сэдэвт зохион бичлэгийн уралдааны удирдамж гарган батлуулж, уралдаанд дүүргийн Ерөнхий боловсролын 10 сургуулийн нийт 56 сурагчид хамрагдсан. Дүүргийн хэмжээнд дүнг гарган эхний 1,2,3 дугаар байр эзэлсэн сурагчдын шагналыг 2017 оны 03 дугаар сарын 14-ний өдөр зохион байгуулсан өдөрлөгийн арга хэмжээнд гардуулсан.	100
168	Зэвсэгт хүчний 96 жилийн ойн хүрээнд зохион байгуулах уралдаан тэмцээн, цэргийн анги байгууллагын удирдлагыг хүлээн авч хамтран ажиллах ажлыг зохион байгуулна.	Цэргийн штаб	2,580,000					Зэвсэгт хүчний 96 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх арга хэмжээний хүрээнд дүүргийн ЗДТГ-ын албан хаагчдын дунд Цэргийн штабын нэрэмжит “Боулингийн тэмцээн” зохион байгуулан тэмцээнд дүүргийн төрийн албан хаагчдыг бүрэн хамруулсан.	100
169	Сүлжээний мэдээллийн	Цэргийн Штабын Мэдээллийн	650,000				650,000	2017 оны нэгдсэн төлөвлөгөөний дагуу Мэдээллийн аюулгүй байдал, нууц хадгалалт, хамгаалалтын чиглэлээр Тагнуулын	100

	аюулгүй байдал, нууц хадгалалт хамгаалалтыг хангах талаар дүүргийн ЗДТГ, дэргэдэх хэлтэс, албадыг оролцуулан батлан хамгаалах яам, ЗХЖШ, ТЕГ-тай хамтран сургалт зохион байгуулна.	аюулгүй байдлын офицер, ахмад Б.Ганчимэг						ерөнхий газартай хамтран Дайчилгаа удирдах бүлгийн бүрэлдэхүүн болон хорооны Засаг дарга нартай 2017 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр сургалт зохион байгуулсан.	
170	Цэргийн штабын улсын дайчилгааны нууцын өрөөний дохиолол хамгаалалтыг шинэчлэх	Цэргийн Штабын Мэдээллийн аюулгүй байдлын офицер ахмад Б.Ганчимэг	2,000,000					Нууцын өрөөний нууц хадгалалт хамгаалалтад анхаарч, МУ-ын Зэвсэгт хүчний нууцыг хамгаалах журмын дагуу өрөөний дохиоллын шинэ төхөөрөмжийг 2017 оны 04 дүгээр сарын 05-ны өдөр суурилуулан тавьсан.	100
171	Зэвсэгт хүчний цэргийн анги байгуулагуудад явуулах дайчилгааны тодотгол хийнэ.	Цэргийн штабын Дайчилгааны офицер ахмад Н.Насанбат	220,320					Монгол Улсын Дайчилгааны тухай хууль болон бусад эрх зүйн баримт бичгийг үндэслэн 2017 оны 06 дугаар сарын 07-14-ний өдрүүдэд цэргийн дайчилгааны тодотголыг 100 хувь явуулсан.	100
172	Цэргийн дүйцүүлэх албаны анхан болон гүнзгийрүүлэх шатны цэргийн бэлтгэл сургалт зохион байгуулна.	Цэргийн штабын Төлөвлөлт, сургалтын офицер /дэд хурандаа/ Г.Жаргалсайхан	6,835,000				4,945,000	Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Дайчилгааны тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.4, Цэргийн албаны тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.8, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Нийслэлийн Засаг даргын 2017 оны А/608 дугаар захирамжийн дагуу нийслэлийн 9 дүүргийн цэргийн дүйцүүлэх алба хаагч болон 2 дугаар зэргийн бэлтгэл үүрэгтэнтэй “Цэргийн анхан шатны бэлтгэл сургалт”-ыг	100

								<p>Зэвсэгт хүчний 350 дугаар ангийн сургалтын материаллаг баазыг түшиглэн 2017 оны 09 дүгээр сарын 24-ний өдрөөс 10 дугаар сарын 07-ны өдөр хүртэл зохион байгуулан явуулсан.</p> <p>Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын 2008 оны 49 дүгээр тогтоол, дүүргийн Засаг даргын 2017 оны А/363 дугаар захирамжийн дагуу Гал түймэр унтраах, аврах 14 дүгээр ангийн материаллаг баазыг түшиглэн "Цэргийн дүйцүүлэх албан хаагчдын гүнзгийрүүлсэн шатны сургалт"-ыг дүүргийн Онцгой байдлын хэлтэстэй хамтран 2017 оны 11 дүгээр сарын 06-12-ны өдрүүдэд зохион байгуулсан.</p>	
173	Дүүргийн ЕБ-ын сургуулиудын дунд зохион байгуулах уралдаан, тэмцээн	Цэргийн штаб	680,000					<p>Монгол цэргийн өдрийг тохиолдуулан дүүргийн Засаг даргын нэрэмжит цэрэг-спортын цогцолбор "Дөл" тоглолтыг 2017 оны 03 дугаар сарын 9-нд Зэвсэгт хүчний 013 дугаар ангитай хамтран зохион байгуулсан.</p>	100
174	Нийслэл, дүүргүүдийн ЗДТГ-ын Цэргийн штабуудын дунд тэмцээн зохион байгуулах	Цэргийн штаб	450,000					<p>2017 оны 04 дүгээр сарын 08-ны өдөр "Гранд тийм" пэйнтобол клубт нийслэл, дүүргийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын офицер, ахлагч нарын дунд зохион байгуулсан "Пэйнтобол"-ын тэмцээнд Хан-Уул дүүргийн ЗДТГ-ын Цэргийн штабын офицер, ахлагч нар идэвхтэй оролцсон.</p>	100
175	Монгол Улсад "Генерал цолтон" бий болсоны 73 жилийн ойг тэмдэглэн генерал цолтонд хүндэтгэл үзүүлэх	Цэргийн штаб	2,350,100					Төсөв гараагүй.	0
176	Залуучуудад цэрэг эх оронч хүмүүжил олгох, ЗХ-ний үйл	Цэргийн штаб	1,011,200					<p>2017 оны 05 дугаар сарын 26-ны өдөр Энхийг сахиулагчдын өдрийг тохиолдуулан "Монгол цэрэг-Дэлхийн цэрэг" сэдэвт уулзалт, ярилцлагыг Монгол цэргийн музейд зохион</p>	100

	ажиллагааг иргэдэд сурталчлах "Монгол цэрэг-Дэлхийн цэрэг" уулзалт, ярилцлагыг зохион байгуулах							байгуулсан. Дүүргийн ЕБ-ын 5 сургуулийн нийт 100 сурагчид хамрагдсан.	
177	Иргэдэд Батлан хамгаалах хууль тогтоомжийг сурталчлах ажлыг технологийн шинэчлэлд тулгуурлан шинэчлэх "Ухаалаг мэдээлэл" төслийг хэрэгжүүлэх	Цэргийн штаб	9,500,000					Төсөв гараагүй.	0
178	Цэргийн штабын хяналт шалгалтын ажлыг зохион байгуулна.	Цэргийн штаб, төлөвлөлт сургалтын офицер, дэд хурандаа Г.Жаргалсайхан	903,040					2017 оны жилийн эцсийн байдлаар Батлан хамгаалах хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ үнэлгээний ажлыг дүүргийн Засаг даргын баталсан удирдамжаар зохион байгуулан шалгалтад 9 байгууллагын 18-50 насны 1013 цэргийн үүрэгтний нэрийн жагсаалт /4 дүгээр маягтаар/ авч, 847 хүн буюу 83,6 хувийг хамруулснаас 40.8 хувь нь зөрчилтэй байсан. 1971-1991 онд төрсөн 8,5 хувьд нь цэргийн дүйцүүлэх албаны мөнгөн төлбөр тогтоосноос 8,933,334 төгрөгийг нийслэлийн Төрийн санд төвлөрүүлсэн.	100
179	Монгол Улсын Засгийн газрын тогтоолоор зохион байгуулах "Дайчилгаатай команд-штабын болон тусгай	Цэргийн штаб	14,227,700					Зэвсэгт хүчний жанжин штабаас хээрийн сургууль зохион байгуулахгүй гэсэн шийдвэр гарсан.	-

	тактикийн хээрийн сургууль" зохион байгуулах								
180	2018 оны Цэргийн бүртгэлийг хороо, дэвсгэрийн аж ахуйн нэгж байгууллага, их дээд сургуулидад зохион байгуулна.	Цэргийн штаб	7,625,800					2017 оны цэргийн бүртгэлийг 2017 оны 01 дүгээр сарын 04-20-ны өдрүүдэд Засаг захиргааны үндсэн нэгж хороодод төвлөрүүлэн, хорооны Засаг дарга эрхлэн явуулж, ЗДТГ-ын Цэргийн штаб цэргийн мэргэжлийн удирдлагаар ханган ажилласан. Цэргийн бүртгэлд хамрагдах цэргийн үүрэгтэн нийт иргэний 96,4 хувийг бүртгэлд хамруулж, бүртгэлээс хоцорсон иргэн 3,6 хувийг 2 дугаар сард багтаан цэргийн бүртгэлд бүрэн хамруулсан.	100
22 АЖЛЫН БИЕЛЭЛТ 80 ХУВЬТАЙ ХЭРЭГЖСЭН									
НАЙМ. ХУУЛЬ ЗҮЙН ТАСАГ									
181	Дүүргийн Засаг даргын захирамжийн эрх зүйн үндэслэлийг хянаж. хэрэгжилтэд хяналт тавьж, биелэлтийг тооцож, үнэлэлт дүгнэлт өгнө.	Тасгийн дарга Ч.Байгаль						Дүүргийн Засаг даргын А-402, Б-81 захирамжийн төслийг хянаж хууль, эрх зүйн зөвлөгөө мэдээлэл өгсөн байна. ДЗД-ын 2017-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, дүүргийн Эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх 2017 оны зорилтыг хэрэгжүүлэхээр гаргасан Засаг даргын 290 захирамжийн үүрэг болгосон 427 заалтын биелэлтийг хэлтэс, тасгаас авч нэгтгэсэн. Засаг даргын захирамж 97.7% буюу бүрэн хангалттай хэрэгжиж байна.	100
182	Монгол улсын хууль тогтоомж, эрх зүйн сургалтыг төр, захиргаа, аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн дунд зохион байгуулах, төлөвлөгөө гарган ажиллах.	Эрх мэргэжилтэн /П.Мөнхзул/						Эрх зүйн сургалтыг 19 удаа зохион байгуулж, 1611 иргэнийг хамруулж, 4386 ширхэг гарын авлага тараан, 2.114.709 төгрөгийн төсөв зарцуулан ажилласан. Зөвлөгөө өгөх ажлын хүрээнд нийт 10 удаа үйл ажиллагаа зохион байгуулж, 1263 иргэнд зөвлөгөө өгч, 5347 ширхэг гарын авлага тараан, 913900 төгрөгийн төсөв зарцуулан ажилласан байна.	100
183	Гэрээний эрх зүйн	Тасгийн дарга						Засаг дарга болон Засаг даргын Тамгын газрын дарга, хэлтэс,	100

	үндэслэлийг хянах, бүртгэх, хэрэгжилтэд хяналт тавих	Ч.Байгаль						тасгаас иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудтай байгуулах 316 гэрээний төслийг хянаж бүртгэлжүүлсэн байна. 2017 оны байдлаар 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа үйлчилгээний 116 гэрээний мэдээллийг Shilendans.gov.mn сайтад байршуулсан.	
184	Засаг даргын захирамжийн хэрэгжилтийг ublegal.mn сайтуудад байршуулж иргэдэд цахим болон цаасан хэлбэрээр сурталчилна.	Эрх мэргэжилтэн /Б.Очир/ зүйн						Захирамжлалын баримт бичгийн нэгдсэн сайт UBLEGAL.MN цахим санд оруулахад бэлэн болсон. Азийн хөгжлийн сангаас шинэчлэлт, засварын ажил хийгдэж дуусаагүй байна.	90
185	Засаг дарга, Засаг даргын Тамгын газрын эрхлэх асуудлын хүрээнд хамаарах асуудлаар иргэн, хуулийн этгээдээс гаргасан гомдол, маргаан, нэхэмжлэлтэй холбогдуулан итгэмжлэлийн үндсэн дээр хууль хяналтын байгууллагатай харилцана.	Эрх мэргэжилтэн /Б.Очир/ зүйн		25	25			<p>Захиргааны хэргийн шүүхэд :Засаг даргыг төлөөлөн 34 шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцож, 20 хэргийн нотлох баримт болон тайлбар гарган, Шүүхийн 29 үзлэгт биечлэн оролцож ажилласан.</p> <p>9 хэргийн нэхэмжлэлийн шаардлагыг хэрэгсэхгүй, 7 хэргийн нэхэмжлэлийн шаардлагыг хангаж, 2 хэргийг эвлэрч шийдвэрлүүлсэн байна.</p> <p>Мөн 7 хэргийн нотлох баримт, тайлбар өгч, Шүүхийн 12 үзлэгт биечлэн оролцож ажилласан байна.</p> <p>Засаг даргын Тамгын газрын даргыг төлөөлөн захиргааны хэргийн 7 шүүх хуралд итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр томилогдсоноос 2 хурлын урьдчилсан хэлэлцүүлэгт орсноос 1 шүүхийн шийдвэр нэхэмжлэгчийн талд шийдвэрлэгдэн гарсан.</p> <p>Иргэний хэргийн шүүхэд</p>	100

								Засаг даргыг төлөөлөн 1 иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд биечлэн оролцсоноос шүүгчийн 3 захирамж, шүүхийн 1 шийдвэр Засаг даргын талд шийдвэрлэгдэн гарсан. Засаг даргын Тамгын газрын даргыг төлөөлөн 1 иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд биечлэн оролцсоноос шүүхийн 1 шийдвэр нэхэмжлэгчийн талд шийдвэрлэгдэн гарсан.	
186	Дүүргийн Засаг даргын захирамжид котификаци хийх, данс бүртгэлийн тэмдэглэл хийх	Эрх мэргэжилтэн зүйн П.Мөнхзул						Засаг даргын 2016 оны захирамжаар өмнөх онуудын захирамжид 634 кодификаци хийх ажлыг зохион байгуулж гүйцэтгэсэн. Дээрх ажил хийгдсэнээр баримтын архивт мэдээлэл үнэн зөвөөр хадгалагдах боломж бүрдэж байна.	100
6 АЖЛЫН БИЕЛЭЛТ 98.3 ХУВЬТАЙ ХЭРЭГЖСЭН									
ЗДТГ-ЫН 2017 ОНЫ КАЛЕНДАРЧИЛСАН ТӨЛӨВЛӨГӨӨНД ТУСГАГДСАН 186 АЖЛЫН БИЕЛЭЛТ 95.1 % ХЭРЭГЖСЭН БАЙНА.									